

Агуулга.....	Error! Bookmark not defined.
ӨМНӨХ ҮГ	2
УДИРТГАЛ	3
Нэр томъёоны тайлбар.....	7
НЭГ. 6-21 насны хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийн шалгуур	9
ХОЁР. 6-21 настай хүүхэд, залуучуудын танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт	32
ГУРАВ. 6-21 настай хүүхэд, залуучуудын нийгэмшлийн шалгуур үзүүлэлт	43
Ашигласан материал	56

Хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлогийг тусгасан, түүнийг харгалзан үзсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, харилцаа нь аль ч улс орны боловсролын салбарынхны нэн тэргүүний зорилт байдаг. Үүнтэй холбоотойгоор хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, стандартыг насны үе шат эсвэл боловсролын түвшинд баримжаалан боловсруулж, даган мөрддөг дэлхийн улс орнуудын туршлага байна.

Засгийн Газрын 2010 оны 173 дугаар тогтоолын хавсралт “ Монгол Улсын шинжлэх ухаан технологийг хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл 2010-2014 он”-ы тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх цөм технологийн жагсаалтад “Хүний хөгжил, төлөвшил, боловсролын шинэчлэлийн технологи”-ийг “Хүний хөгжил, амьдралын чанар тэргүүлэх чиглэл”-ийн хүрээнд багтаасан байна. Үүнтэй холбоотой хүүхэд, залуучуудын хөгжлийн цогц судалгааг цөм технологи бий болгох зорилтоор хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд тулгуурлан хөгжлийн шалгуур үзүүлэлтийг боловсролын түвшинд баримжаалан боловсрууллаа. Хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур үзүүлэлтийг шат шатны боловсролын байгууллагын ажилтнууд бодлого боловсруулах, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, баримт бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад, багш, ажилтнууд, эцэг, эхчүүд, хүүхэд, залуучуудтай ажилладаг өөр бусад хүмүүс төдийгүй хүүхэд залуучууд өөрсдөө хөгжлийн онцлогоо танин мэдэх, дэмжих үйл ажиллагаанд хэрэглэх бүрэн боломжтой юм. Шалгуур үзүүлэлтийн агуулга нь бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хамрагдах насны буюу 6-21 настай хүүхэд, залуучуудын бие бялдар, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн нас зүйн онцлог, хүрсэн байх түвшин, түүний илрэлийг багтаасан. Иймд энэхүү баримт бичгийн хэрэглээг хязгаарлах нь зохимжгүй ба хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлогийг мэдэх, хөгжлийг нь дэмжихэд чиглэсэн ямар ч үйл ажиллагаанд хэрэглэж болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийг боловсруулахад хамтран ажилласан доктор П.Цэрэндондов, О.Мягмар, Ж.Батдэлгэр, Б.Туяа, Б.Мөнгөнцэцэг, Ж.Баянсан, Л.Уртнасан, Л.Гүндэгмаа; Сэтгэл судлалын үндэсний төвийн хамт олон болон Б.Ууганцэцэг нартаа гүн талархал илэрхийлье.

Хүний хөгжлийн судалгааны сектор

6-21 настай хүүхэд залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийг “Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлтийн технологийг сургалтын практикт нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнд тулгуурлан боловсрууллаа. Шалгуур үзүүлэлт нь бие бялдар, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн онцлогийг судалсан судалгааны дундаж үзүүлэлт, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл дээр үндэслэгдсэн. Бие бялдарын шалгуур үзүүлэлт нь бие бялдарын хөгжил, бэлтгэлжилт гэсэн хөгжлийн 2 дэд бүрдлийг агуулна. Танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт нь мэдээллийг хүртэж хүлээж авах, боловсруулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадвар ба хэл ярианы хөгжил гэсэн хөгжлийн 2 дэд бүрдэлтэй. Нийгэмшлийн шалгуур үзүүлэлт нь өөртөө хандах хандлага, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа, ээнэгшилт, дасан зохицолт, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээ гэсэн дэд бүрдлүүдээс бүрдэнэ.

Бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хамрагдах насны 6-21 настай хүүхэд, залуучуудын хөгжлийг:

- Бие бялдар, танин мэдэхүйн хөгжлийн хүрсэн байх доод хязгаар, түүний бодит илрэл;
- Нийгэмшлийн ерөнхий онцлогийг өөртөө хандах хандлага, зан төлөв, сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээний хүрээний илрэлийн ерөнхий шинжээр нь авч үзэв.

Бид “хүүхэд” гэсэн бүлэгт 6-10 настай бага ангийн хүүхдүүд, 11-14 настай дунд ангийн хүүхдүүд, 15-17 настай ахлах ангийн хүүхдүүдийн хамруулан авч үзэв.

“Залуучууд” гэдэгт 18-21 настай мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хамрагдах насны хүн ам зүйн бүлгийг хамаарууллаа.

Энэхүү шалгуур, үзүүлэлтийг хүүхэд, залуучуудын хөгжлийг үнэлэх, дэмжих бүхий л үйл ажиллагаанд баримжаалал болгон ашиглах боломжтой.

Монголын хүүхэд, залуучуудын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн шалгуур, үзүүлэлт, түүний хэрэглээ

6-21 настай хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур, үзүүлэлт нь тэдний бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн онцлог шинж, чадваруудыг боловсролын түвшингээр илэрхийлсэн баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь бага, суурь, бүрэн дунд, дээд боловсролын түвшинд хамрагдах насны хүүхэд, залуучууд бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадварын хувьд хамгийн наад зах нь ямар шаардлага, шинжийг хангахыг зааж өгсөн. Тухайн боловсролын түвшин тус бүрд хамрагдах насны хүүхэд, залуучууд бие бялдар, танин мэдэхүйн, нийгэмшлийн чадамжийн хүрээнд ямар чадваруудтай байх буюу юу чаддаг байх нь зохимжтой, энэ нь ямар илрэлтэй болох нь баримт бичгийн гол агуулга юм.

Зорилго: Бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролд хамрагдах насны хүүхэд, залуучуудын хөгжлийн (бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшил) хүрэх түвшин, хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлоход оршино.

Зорилт:

- Бага боловсролд хамрагдах 6-10 насны хүүхдийн хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Бага боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл болно.
- Суурь боловсролд хамрагдах 11-14 насны хүүхдийн хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Суурь боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл болно.
- Бүрэн дунд боловсролд хамрагдах 15-17 насны хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Бүрэн дунд боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих мөн тэд өөрийн хөгжлийг баримжаалан удирдахад чиглэл болно.
- Мэргэжлийн болон дээд боловсролд хамрагдах 18-21 насны хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог, хүрэх түвшин, хэмжих үзүүлэлт тодорхой болно. Мэргэжлийн болон дээд боловсролын бодлогын үндэслэл болохоос гадна боловсролын байгууллагын багш ажилтан, эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих мөн тэд өөрийн хөгжлийг баримжаалан удирдахад чиглэл болно.

Хэмжигдэхүйц, харагдахуйц, насны онцлогт тохирохуйц, хөгжлийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн харилцан шүтэлцээнд авч үзэх гэсэн зарчмууд дээр үндэслэн шалгуур үзүүлэлтийг боловсруулсан.

Онцлог нь:

- 6-21 насны бүлэг бүрээр хүрэх түвшин, үзүүлэлтийг тусгасан.
- Шалгуур, үзүүлэлтийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн судалгаанд үндэслэн боловсруулсан.

Зориулалт

Шалгуур, үзүүлэлтийг хүүхэд, залуучуудтай холбоотой ажил эрхэлж байгаа болон тэдэнтэй холбогдох бүхий л байгууллага, иргэн, хувь хүн өөрсдийн эрхэлдэг ажлын онцлог, зорилготой уялдуулан ашиглана. Боловсролын салбарын холбогдох мэргэжилтэн, иргэдийн хувьд дараах чиглэлээр ашиглах боломжтой. Үүнд:

- Бодлого боловсруулагчид тодорхой түвшинд хамаарах бодлогын баримт бичиг боловсруулах, хөгжлийн хөтөлбөр боловруулахад хамаарах насны хүүхдийн хөгжлийн онцлогийг тооцох,
- Боловсролын үндэсний байгууллагын хувьд үндэсний хөтөлбөр боловсруулах, сурах бичиг, сургалтын төлөвлөгөө боловсруулахад, багшийн мэргэжил дээшлүүлэхэд агуулга аргазүйтэй холбоотой шийдвэр гаргахад тухайн насны хүүхдийн хөгжлийн онцлогийг тооцох,
- Сургалт эрхэлж буй боловсролын байгууллагын хувьд хичээлийн хөтөлбөр, аргазүй, зохион байгуулалтыг боловсрогуй болгох, хичээлээс гадуурх үйл ажиллагааны агуулга, арга хэлбэр, зохион байгуулалт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг хүүхдийн насны онцлогт нийцүүлэхэд, гэр бүл, эцэг, эхчүүдэд чиглэсэн үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр боловсруулах ашиглах,
- Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхдийн хөгжлийн талаар шинжлэх ухааны үндэстэй баримжаатай болох, онцлогийг мэдэх улмаар хүүхдийнхээ хөгжлийг дэмжсэн амьдралын орчин, нөхцөл, харилцааг бүрдүүлэх,
- Хүүхэд, залуучуудын хувьд өөрийн хөгжлийн талаар ойлголттой болж, хөгжлийг зорилго чиглэлтэйгээр удирдах болно.

Хэрэглээнд баримтлах шаардлага

- *Хувийн онцлог шинж.* – Хүүхэд, залуучуудын хувийн давтагдашгүй өвөрмөц онцлогийг таних, ойлгох, хүндэтгэлтэй хандан, хүлээн зөвшөөрөх
- *Тэгш байх*- Бага, суурь, бүрэн дунд, дээд болон мэргэжлийн боловсролд хамрагдах насны бүх хүүхэд залуучуудад тэгш үйлчилнэ. Үндэс, угсаа, нийгмийн гарал, байр сууриас хамаарсан ялгаатай байдал байхгүй
- *Нийцтэй байх*-Хөгжлийг шалгуур, үзүүлэлтийн хэмжигдэхүйц хүрээнд баримжаална. Хүүхэд, залуучуудын хөгжлийн түвшин, онцлогийг үнэлэх, харьцуулахдаа шалгуур, үзүүлэлтэд баримжаална. Өөр бусад тохиолдолд стандарт үндэслэл болохгүй.
- *Зорилгод баримжаалах*-Хүүхэд, залуучуудын хөгжлийг үнэлэх, дэмжих бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн стандартын хэрэглээ янз бүр байж болно.

- *Хөгжлийг дэмжих*-Хүний хөгжил, үйл ажиллагааны чанар үр дүнг шууд үнэлэх үнэлгээний болон урамшуулал, сануулга гэх мэт арга хэмжээний хэрэгсэл болохгүй. Энэ нь зөвхөн хүүхэд, залуучуудын хөгжлийг бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хүрээнд дэмжих үйл ажиллагааны чиглэлийн үүрэгтэй.
- *Хамтын ажиллагаанд тулгуурлах*- Гэр бүл, шат шатны боловсролын ба сургалтын байгууллагын хамтын ажиллагааны нэгдэлд тулгуурлана.
- *Идэвхтэй оролцоонд тулгуурлах*-Хөгжлийг дэмжихэд чиглэсэн аливаа бодлого, баримт бичиг, харилцаа, үйл ажиллагаа нь хүүхэд, залуучуудын бие даасан үйл ажиллагаагаар хэрэгжих бөгөөд “*өөрөө үйлдэх замаар сурч хөгжинө*” гэдэгт баримжаалах нь зүйтэй.

Нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Тайлбар
Шалгуур Criteria; Критерий	Юмс үзэгдлийн илрэлийг үнэлэх, шийдвэр гаргах шаардлага үндэслэл.
Үзүүлэлт Indicator; Индикатор	Юмс үзэгдлийн илрэл, түүний шинж чанарын тоон болон чанарын илэрхийлэл. Үзүүлэлт нь харагдахуйц, хэмжигдэхүйц байна. Тоон үзүүлэлт нь тодорхой утга илэрхийлсэн тоон илэрхийлэл. Дүрслэлийн үзүүлэлт нь өнгө, хэлбэр, дүрс байж болно. Үгэн илэрхийлэл нь утга бүхий үг, хэллэг гэх мэт байна.
Бие бялдрын хөгжил Physical development; Физические развитие	Хүний хөгжлийн суурь болсон бие махбодийн хөгжил болох өндөр, жин, биеийн харьцаа, биеийн чанарууд, дотоод эрхтэн тогтолцооны хөгжил болох физиологийн хөгжил юм.
Бие бялдрын бэлтгэлжилт Physical fitness; Физическая подготовленность	Тодорхой зорилготой бэлтгэлийн үр дүнд төлөвшин тогтсон хөдөлгөөний болон ажиллах чадвар. Бие бялдрын бэлтгэлжилтийг хурд, хүч, тэсвэр, авхаалж самбаа, уян хатан гэсэн 5 чанараар тодорхойлно. Тэсвэр - Булчингийн үйл ажиллагааны явцад гарах биеийн ядралтыг эсэргүүцэх чадвар. Авхаалж самбаа – энэ нь нарийн төвөгтэй үйлдлийг хөдөлгөөний тэнцвэрээ олж зөв, авхаалжтай гүйцэтгэх чадварыг хэлнэ. Хүч – гаднын эсэргүүцлийг даван туулах, эсвэл түүнийг булчингуудынхаа хүчээр эсрэг үйлчлэл үзүүлэх чадвар. Уян хатан – хөдөлгөөнийг хамгийн их далайцтай гүйцэтгэх чадвар.
Танин мэдэхүйн хөгжил Cognitive development; Когнитивная развития	Сэтгэн бодох үйл ажиллагааны төрлүүд буюу буюу хүртэхүй, ой тогтоолт, ухагдахуун төлөвшил, асуудлыг шийдвэрлэх, учир шалтгаанд нь сэтгэх сэтгэхүйн процессуудын хөгжил.
Хөгжлийн бүрдэл Domain Домайн	Бүхэл зүйлийг бүрдүүлэх үндсэн нэгж хэсэг. Хүүхдийн хөгжил бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшил гэсэн бүрдэлтэй.
Цогц чадамж Competence Компетенция	Бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн чадваруудын цогц бөгөөд хүний идэвх зан үйлийн хөдөлгөгч хүч.
Танин мэдэхүйн хөгжил Cognitive development; Когнитивная развития)	Сэтгэн бодох үйл ажиллагааны төрлүүд буюу буюу хүртэхүй, ой тогтоолт, ухагдахуун төлөвшил, асуудлыг шийдвэрлэх, учир шалтгаанд нь сэтгэх сэтгэхүйн процессуудын хөгжил.

Анхаарал Attention; Внимание	Хүний сэтгэцийн үйл ямар нэгэн мэдээлэл, юмс үзэгдэл, үйл ажиллагаанд төвлөрөх үйл явц. Зориудын ба зориудын бус, хожуу идэвхжих анхаарал гэж 3 хуваана. Мэдээлэл цочроогчдод зориудаар идэвхтэй анхаарлаа хандуулах нь зориудын анхаарал. Янз бүрийн мэдээлэл - цочроогчдод санаандгүйгээр анхаарлаа хандуулахыг зориудын бус анхаарал. Зориудын бус анхааралтай ойролцоо шинжтэй, үйл ажиллагааны явцад хүний сонирхол эсвэл хандлагатай нь холбоотойгоор үүсэж буй анхаарлын төвлөрлийг хожуу идэвхжих анхаарал гэнэ.
Ой тогтоолт Memory; Память	Мэдээллийг тогтоох, хадгалах, сэргээн санах процесс. Ой тогтоолтод оролцож буй сэтгэцийн үйлийн онцлогоор нь хөдөлгөөний, сэтгэлийн хөдөлгөөний, дүрслэлийн, үг яриа-утгын ой тогтоолт гэж ангилдаг. Зорилго хүчин чармайлтын оролцоогоор нь зориудын ба зориудын бус ой тогтоолт гэж ангилна. Мэдрэхүйн эрхтний оролцоогоор нь харааны, сонорын, хүрэлцэхүйн, үнэрлэх, амтын ой тогтоолт гэж ангилна.
Сэтгэхүй Thinking; Мышление	Юмс үзэгдлийн шинж чанар харилцаа холбоог нэгтгэн дүгнэх дам тусгал бүхий танин мэдэхүйн дээд шат. Сэтгэхүй нь хүн өмнөө шинэ зорилго тавих, түүнийгээ төлөвлөх, зорилгоо биелүүлэх шинэ арга хэрэгсэл боловсруулах, асуудлыг шийдвэрлэх, хүмүүсийн харилцан ойлголцолд үүрэгтэйгээс гадна мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ангилах сэтгэхүйн үйлдлийн тусламжтайгаар мэдээллийн гол утгыг хийсвэрлэн ойлгож, нэгтгэн дүгнэх үүрэгтэй. Хэлбэрээр нь бодит үйлдлийн сэтгэхүй, бодит дүрслэлийн сэтгэхүй, хийсвэр сэтгэхүй гэж ангилна.
Хүртэхүй Perception; Восприятие	Хүний мэдрэхүйн эрхтэнд үйлдэл үзүүлсэн юмс үзэгдлийн талаарх уураг тархинд туссан дүр төсөөлөл. Юмс үзэгдлийн талаарх бүхэл бүтэн дүр төсөөлөл үүсэх сэтгэц-физиологийн нарийн үйл явц.
Хэл ярианы хөгжил Language development; Вербальные способности	Насанд хүрэгчдийн тусламжтайгаар харилцааны үр дүнд үг яриаг ойлгох, үгийн нөөцтэй болох, өгүүлбэрээр ярих чадвар эзэмших үйл явц.
Ухагдахуун төлөвшил Concept formation; Формирование понятия	Бодит зүйлийн гол шинжийг тусгаж, хийсвэрлэсний үр дүнд тогтсон ухагдахуун эзэмших.
Ярих чадвар Verbal ability; Речь устная	Бодол санааг ойлгох, аман хэлээр илэрхийлэх чадвар.

Нийгэмшил Socialization; Социализация	Хувь хүн бүлэг хүмүүс буюу нийгэмд зохицохын тулд нийгмийн хэм хэмжээ, үзэл баримтлал, эерэг хандлага, харилцааны чадвар эзэмших тасралтгүй үйл явц.
Зан төлөв Character; Характер	Орчны нөлөөгөөр төлөвших хандлагын илрэл.Энэ нь олон тооны шинжүүдээс бүрддэг бөгөөд хүний зан үйл, амьдралын хэв маягийг нь тодорхойлно. (хариуцлагатай, нийтэч, нөхөрсөг, идэвхтэй, хөгжилтэй, гунигтай, аймхай гэх мэт)
Нийгмийн хэм хэмжээ Social norms; Социальная норма	Нийгмийн бүлэг, хамт олон, бүлэглэлийн хүрээнд баримталбал зохих дүрэм журам, зохистой хариу үйлдэл.
Харилцаа Communication; Общение чадваруудаас бүрдэнэ.	Харилцааны чадвар нь бусадтай хамтрах буюу үр дүнтэй харилцах, бусдаас дэмжлэг хүсэх, бусдын сэтгэл санааг ойлгож харилцах, түүнийгээ зөв илэрхийлэх
Сэтгэлийн хөдөлгөөн Emotion; Эмоция	Бодит байдал, юмс, үзэгдэлд хандах дотоод сэтгэлийн тогтвортой хандлага. Хүний сэтгэлийн хөдөлгөөний хөгжил нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгох,илэрхийлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах чадварыг агуулна.
Үнэт зүйл Values; Ценность	Хүний амьдралын баримжаа болж буй эрхэмлэн дээдэлдэг, чухал ач холбогдолтой зүйлсийн талаарх итгэл үнэмшил
Өөртөө хандах хандлага Self-perception; Самосознание	Өөрийгөө хүлээн зөвшөөрөх, өөртөө итгэх итгэл,өөрийн үнэлэмжийн эерэг болон сөргөөр үнэлгээ
Эзэнгшилт Attachment; Привязанности	Хүүхдийн нялх, балчир насанд бий болдог ба хүүхэд эцэг эх, өөр бусад асран хамгаалагчиддаа хандах сэтгэлийн хөдөлгөөний эерэг, таатай, бат бөх, тогтвортой, цаг хугацаанаас үл хамаарах хандлага бөгөөд энэ нь хүүхдийн харилцаа, сэтгэлийн хөдөлгөөний хөгжилд чухал үүрэгтэй байдаг бүрдэл. Хүүхэд эцэг эхтэйгээ идэвхтэй харилцах, тэдэнд итгэх, ойр дотно хандах хандлагаар илэрнэ.

НЭГ. 6-21 насны хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийн шалгуур

Өсөлт гэдэг нь биемахбодид явагдаж байгаа нэгэн процессийн хоорондоо харилцан уялдаатай хоёр тал юм. Өсөлт нь биемахбодид бүхэлдээ болон тусгай эд эрхтэн хэмжээний хувьд байгалийн жам ёсоороо өсөн нэмэгдэх тооны өөрчлөлт

юм. Насны үе шат бүрд биемахбодийн өсөлт хөгжилт нь харилцан адилгүй удааширах, хурдсах зэргээр явагдах бөгөөд түүний үндэс нь бодисын солилцоо юм (Д.Батчулуун, Ч.Цолмон,1990).

Бие бялдрын хөгжилт гэдэг нь хүний бие махбодийн бүтэц - үйл ажиллагааны шинж чанар нь амьдралынхаа туршид хувьсан өөрчлөгдөх биологийн явц юм. Энэ явц хувь хүний амьдралын туршид тэдний бие махбодийн бүтэц үйл ажиллагааны шинж чанарууд, тэдгээрт үүсэх бие бялдрын чанарууд, чадваруудын дараа дараагийн өөрчлөлт юм. Хүүхэд болон насанд хүрэгчдийн амьдрах нөхцөл, эрүүл мэндийн байдлын тодорхойлох чухал хүчин зүйлийн нэг бие бялдрын хөгжил юм.

Бие бялдрын хүмүүжлийн онол арга зүйн шинжлэх ухаанд бие бялдрын бие бялдрын хөгжлийг биеийн тамирын дасгалын нөлөөгөөр хүний бие махбодид дэвшилтэт өөрчлөлт гарахыг хэлнэ гэж тодорхойлдог.Бие бялдрын хөгжил нь 3 бүлэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр тодорхойлогдож байдаг. Үүнд:

1. Бие махбодийн бүтэц (биеийн урт, биеийн жин, галбир, биеийн хэсгүүдийн хэлбэр хэмжээ, өөхөн давхаргын хэмжээ ба бусад)-н үзүүлэлтүүд.Эдгээр нь юуны өмнө хүний бүтэц зүйг тодорхойлж байдаг.
2. Хүний бие махбодийн бүтэц ба физиологийн системүүдийн үйл ажиллагааны өөрчлөлтүүдийг харуулж байгаа эрүүл мэндийн үзүүлэлтүүд. Бид баруун зүүн гарын атгах хүч (гарын сарвууны булчингийн атгах хүчийг илэрхийлнэ), уушгины амьсгал дээд гаргах хурд (уушгины булчингийн физиологийн ажиллах чадварыг илэрхийлнэ) зэрэг үзүүлэлтүүдийг судлан тогтоосон юм.
3. Бие бялдрын чанарууд (хүч, хурд, эвсэл дүйн чадварууд,тэсвэр хатуужил, уян хатан болон бусад чанарууд)-ын хөгжлийн үзүүлэлтүүд.

Бие бялдрын бэлтгэлжилт нь биеийн чанаруудыг зорилго-чиглэлтэйгээр хөгжүүлэх, бие бялдрын чадвар дадал эзэмших зохион байгуулалттай сурган хүмүүжүүлэх явц, бие бялдрын бэлтгэлийн үр дүн.

Бие бялдрын хөгжлийн шалгуур нь бие бялдрын хөгжилт, бие бялдрын бэлтгэлжилт гэсэн хоёр дэд хэсэгтэй.

Монголын хүүхэд залуучуудын бялдрын хөгжлийн шалгуурын үндсэн үзүүлэлт болох, биеийн өндөр, биеийн жин үзүүлэлтүүдийг нас хүйс тус бүрээр дундаж түвшин, дундаас дээгүүр буюу дундаас доогуур, мөн дээгүүр ба доогуур гэсэн 5 түвшинтэй шалгуурын ДЭМБ-аас практикт өргөн хэрэглэдэг прецентилийн аргаар Statistica Softwear 8 программ дээр боловсруулан гаргалаа. Тухайлбал, 6 настай эмэгтэй хүүхдийн биеийн өндрийн дундаж үзүүлэлт 112.4 - 118.9 см байх бөгөөд 109,75 см хүртэлх үзүүлэлттэй бол дундаас доогуур, түүнээс доош бол доогуур өсөлтийн түвшинтэй буюу намхан хүүхэд гэж үзнэ. Харин 6 настай дундаж түвшинээс 121,9 см хүртэлх нь дундаас дээгүүр буюу түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

7 насанд эмэгтэй хүүхдийн биеийн өндөрийн дундаж үзүүлэлт 117.1 – 123.9 см байх бөгөөд 112,6 см хүртэлх үзүүлэлттэй бол дундаас доогуур, түүнээс доош бол доогуур өсөлтийн түвшинтэй буюу намхан хүүхэд гэж үзнэ. Харин 7 настай дундаж түвшинээс 127,9 см хүртэлх нь дундаас дээгүүр буюу түүнээс дээш үзүүлэлттэй бол дээгүүр үзүүлэлт буюу өндөр хүүхэд гэж үзнэ.

Хөгжлийн бүрдэл. Бие бялдар

Цогц чадамж 1. Бие бялдрын хөгжил (6-10 нас)

Бага боловсрол (6-10 нас)	Биеийн өндөр (см)										
	Биеийн өндрийн үзүүлэлт жилд охидууд 6-7 насанд 5см, 7-8 насанд 7 см, 8-9 насанд 5 см 9-10 насанд 6.0 см -ээр өссөн, хөвгүүд 6-7 насанд 6см, 7-8 насанд 6 см, 8-9 насанд 5 см 9-10 насанд 4.0 см -ээр өссөн байна.Хүүхдийн 4 - 7 нас хүртэл эрчимтэй өсөлтийн хоёр дахь үе бөгөөд өндрийн хэмжээ жил бүр 5-7 см нэмэгдсэн.										
	Шалгуур	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
	Үзүүлэлт	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	122.0	123.0	127.0	128.0	136.0	122.0	139.0	127.0	146.0	130.0
	Дунджаас дээгүүр	118.0	119.0	124.0	126.0	131.0	124.0	13.0	129.0	142.0	133.0
	Дундаж	115.0	116.0	120.0	122.0	127.0	128.0	132.0	133.0	138.0	137.0
	Дунджаас доогуур	111.0	113.0	117.0	117.0	123.0	131.0	128.0	137.0	133.0	141.0
Сул	109.0	109.0	113.0	115.0	119.0	136.0	124.0	142.0	130.0	145.0	

Бага боловсрол (6-10 нас)	Биеийн жин (кг)											
	Шалгуур	Биеийн жингийн үзүүлэлт жилд охид 6-7 насанд 2кг, 7-8 насанд 3-4 кг, 8-9 насанд 3 кг 9-10 насанд 3 кг -аар нэмэгдсэн, хөвгүүд 6-7 насанд 2кг, 7-8 насанд 3-4 кг, 8-9 насанд 2 кг 9-10 насанд 2 кг -аар нэмэгдсэн.										
	Хүйс	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас		
	Үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	
	Дээд	25.0	19.0	28.0	21.0	34.0	23.0	36.0	26.0	41.0	27.0	
	Дунджаас дээгүүр	23.0	20.0	25.0	22.0	30.0	24.0	32.0	27.0	36.0	30.0	
	Дундаж	21.0	22.0	23.0	24.0	27.0	28.0	30.0	31.0	33.0	33.0	
	Дунджаас доогуур	19.0	23.0	21.0	26.0	24.0	30.0	26.0	33.0	29.0	35.0	
Сул	18.0	26.0	20.0	29.0	22.0	35.0	24.0	39.0	27.0	40.0		

Бага боловсрол (6-10 нас)	Цээжний тойрог										
	Бага ангийн 6-10 насны хүүхдүүдийн цээжний тойрог жилд 1.4 – 2.9 см -р нэмэгддэг. 6-8 нас хүртэл эрчимтэй өсөлтийн үе 2.2 – 2.9 см нэмэгдэж байхад, 8-11 насанд цээжний тойргийн өсөлтийн эрчим нь бага зэрэг буурч 1.4 -1.9 см -р нэмэгдэнэ.										
	Шалгуур	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
	Хүйс	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	61.0	63.0	65.0	65.0	68.0	69.0	70.0	70.0	73.0	72.0
	Дунджаас дээгүүр	59.0	60.0	62.0	62.0	65.0	65.0	66.0	67.0	68.0	68.0
	Дундаж	57.0	58.0	59.0	60.0	62.0	62.0	63.0	64.0	65.0	66.0
	Дунджаас доогуур	55.0	56.0	57.0	58.0	57.0	59.0	60.0	61.0	62.0	64.0
	Сул	54.0	54.0	55.0	56.0	56.0	57.0	58.0	59.0	60.0	61.0

Бага боловсрол (6-10 нас)	Баруун , зүүн гарын атгах хүч																				
	Бага ангийн 6-10 насны хүүхдүүдийн том булчин нилээд хөгжиж булчингийн чадал нэмэгдэх боловч, гарын сарвууны булчин зэрэг жижиг булчингийн хөгжилт хангалтгүй байдаг бөгөөд жилд 1 – 2 кг нэмэгддэг байна. Баруун гарын атгах хүч, зүүн гарын сарвууны атгах хүчнээс 1 - 2 кг илүү байна.																				
	Шалгуур	6 нас				7 нас				8 нас				9 нас				10 нас			
	үзүүлэлт	Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд	
		б	з	б	з	б	з	б	з	б	з	б	з	б	з	б	з	б	з	б	з
Дээд	8	7	10	10	10	9	11	10	13	12	15	13	15	15	19	17	18	17	19	18	
Дунджаас дээгүүр	7	6	9	8	8	8	10	9	10	10	13	11	13	12	15	15	15	14	17	15	
Дундаж	5	5	6	6	6	6	8	8	8	8	10	10	10	11	12	12	12	12	14	13	
Дунджаас доогуур	4	4	5	5	5	5	6	6	6	6	8	8	9	8	10	10	10	10	11	11	
Сул	3	3	4	4	3	3	5	5	5	5	6	6	6	6	7	7	8	8	10	9	

Бага боловсрол (6-10 нас)	Шалгуур	Уушгины амьсгал гаргах хурд									
	Долоон насанд уушгины эдийн хэлбэржих процесс үндсэндээ дуусаж, амьсгал нь гүнзгий болж амьсгалын давтамжийн тоо багасдаг. 6-7 насанд 1 минутанд 20-22 удаа амьсгална. 8-11 насанд уушгины эдийн өсөлт үргэлжилж амьсгалын гүн, минутын эзлэхүүн 1 минутанд 18-20 удаа амьсгална. Уушгины амьсгал гаргах дээд хурд нь 6 насанд охидын хэвийн үзүүлэлт 136 л/мин, хөвгүүдийн үзүүлэлт - 138 л/мин байсан бол 10 насанд охидын 218л/мин, хөвгүүдийн үзүүлэлт 238 л/мин болж нэмэгддэг байна.										
	Үзүүлэлт / нас	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
	Хүйс	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	170.0	200.0	200.0	230.0	230.0	250.0	250.0	300.0	300.0	300.0
	Дунджаас дээгүүр	150.0	170.0	170.0	200.0	200.0	230.0	240.0	250.0	250.0	270.0
	Дундаж	136.0	151.4	150.7	173.6	178.9	193.8	197.2	224.7	218.0	238.0
	Дунджаас доогуур	110.0	130.0	130.0	150.0	150.0	160.0	160.0	200.0	170.0	200.0
Сул	100.0	110.0	100.0	120.0	120.0	150.0	140.0	150.0	150.0	170.0	

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Цогц чадамж 2. Бие бялдрын бэлтгэлжилт (6-10 нас)

Бол- түвшин	Хурд: 30 м ГҮЙЛТ (с) (Босоо гараанаас 30 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)										
Бага боловсрол (6-10 нас)	Сургуулийн бага ангид буюу 6-10 нас хүртэл хугацаанд хүүхдийн гүйлтийн хурд сайжирч, 30 м зайд гүйх хурдны үзүүлэлт ахина. Хэдийгээр 8 наснаас охидын бие бялдрын хөгжил хөвгүүдээс түрүүлэх боловч сургуулийн бага насны хөвгүүд нь охидоос илүү хурдтай байна.										
	Шалгуур	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	6.9	6.7	6.7	6.5	6.4	6.3	6.3	6.2	6.1	6.1
	Дунджаас дээгүүр	7.8	7.6	7.3	7.0	7.1	6.8	6.9	6.7	6.6	6.5
	Дундаж	9.8	9.4	9.5	9.0	8.6	8.3	8.4	8.1	7.9	7.7
	Дунджаас доогуур	10.8	10.7	10.5	10.0	9.8	9.5	9.7	9.2	8.7	8.6
Доод	12.0	11.5	11.7	11.3	11.2	10.8	11.2	10.6	10.5	10.3	

Бол- түвшин	Гарын хүч: ГАР ДЭЭР СУНИАЛТ (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ суниасан тоог тоолно)										
Бага боловсрол (6-10 нас)	Сургуулийн бага насанд хүүхдийн гарын том бүлэг булчингийн хүч бага хөгжинө. Бичих, зурах, будах ажлын нөлөөгөөр гарын сарвууны болон хурууны булчингууд бэхжинэ. Гар дээр суниах тоо жилд дунджаар 1-3 удаагаар нэмэгдэнэ. Ялангуяа 10 наснаас хөвгүүдийн хүч эрчимтэй хөгжиж эхлэх ба энэ насны хөвгүүд гар дээр сунайхдаа охидоос 4-6 удаа илүү суниасан.										
	Шалгуур үзүүлэлт	6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Маш сайн	13	15	14	16	16	17	17	19	17	21
	Дунджаас дээгүүр	11	13	12	14	13	14	14	16	14	18
	Дундаж	9	10	10	11	11	12	12	13	12	15
	Дунджаас доогуур	6	7	7	8	8	9	9	10	9	12
Сул	3	4	4	4	5	6	6	7	6	9	

Бол- түвшин	Хөлийн хүч: БАЙРНААС УРТАД ХАРАЙЛТ (см) (Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно)										
	Бага боловсрол (6-10 нас)	Сургуулийн бага насанд хөлийн хүч нь гарын хүчнээсээ илүү хурдацтай хөгжинэ. Хөлийн түлхэлтийн хүч хүүхдийн нас нэмэгдэх тусам сайжирна. Энэ нь тэд өдөр тутам алхах, гүйх, үсрэх харайх хөдөлгөөний үйлдлийг олон хийдэгтэй холбоотой. Бага боловсролын түвшинд аль ч насанд биеийн өндрөөрөө охид илүү байгаа боловч байрнаас уртад хөвгүүд нь охидоос хол харайж байна. Ялангуяа 10 насанд хөвгүүд охидоос дунджаар 20 см илүү үзүүлэлттэй байна.									
Шалгуур үзүүлэлт		6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Маш сайн		100	110	120	125	130	135	135	150	145	165
Дунджаас дээгүүр		95	105	110	120	120	125	125	140	135	155
Дундаж		90	100	100	110	110	120	120	135	125	145
Дунджаас доогуур		85	90	90	105	100	110	110	120	115	130
Сул		75	80	80	95	85	105	100	110	105	120

Бол- түвшин	Хөдөлгөөний эвсэл: 3x10 м ГҮЙЛТ (с) (10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ)										
	Бага боловсрол (6-10 нас)	Хүүхэд орон зайг баримжаалан өөрийн хөдөлгөөнөө удирдаж, хөдөлгөөний үйлдлийг хурдтай гүйцэтгэх эвслийн чадавх сургуулийн бага наснаас эрчимтэй хөгжиж эхэлнэ. Ялангуяа нарийн эв дүй хэрэгцээт хөдөлгөөний чадвар хөгжих үндэс суурь сургуулийн бага насанд тавигдана. Хөдөлгөөний эвсэл шаардсан үйлдлийг ихэнх тохиолдолд хурдтай гүйцэтгэдэг учраас орон зайд биеэ хурдан шилжүүлэн, эргэж гүйх чадвар 6-10 нас хүртэл жигд сайжирч байна.									
Шалгуур үзүүлэлт		6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Дээд		10.2	10.0	10.0	9.5	9.5	9.2	9.0	9.0	8.5	8.5
Дунджаас дээгүүр		11.0	10.5	10.5	10.0	10.2	9.5	9.5	9.2	9.2	8.8
Дундаж		12.0	11.5	11.5	11.0	11.0	10.5	10.5	10.0	10.0	9.8
Дунджаас доогуур		13.5	12.5	12.5	11.5	11.5	11.0	11.2	10.5	10.5	10.2
Сул		14.5	14.0	13.5	12.5	13.0	12.0	12.5	11.8	11.5	11.5

Бол- түвшин	Тэсвэр: 300 м, 500 м ГҮЙЛТ (мин) (Босоо гараанаас 300 м ба 500 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)										
	Бага боловсрол (6-10 нас)	Хүүхдийн амьсгалын ба зүрх судасны эрхтэн, тогтолцооны үйл ажиллагаатай уялдаж бага насны хүүхэд нэг төрлийн дасгалыг удаан үргэлжлүүлэх тэсвэр муу байна. Ялангуяа охид 10 насанд, хөвгүүд 8 насанд тэсвэрийн үзүүлэлт илүү ахисан байна. 300 м ба 500 м зайг гүйж туулах тэсвэр сургуулийн бага насанд ч хөвгүүдэд охидоос илүү байна.									
Шалгуур үзүүлэлт		6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		300 м гүйлт				500 м гүйлт					
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Маш сайн		2.30.0	2.22.0	2.12.0	2.06.0	2.50.0	2.30.0	2.43.0	2.12.0	2.32.0	2.04.0
Дунджаас дээгүүр		2.50.0	2.42.0	2.32.0	2.26.0	3.10.0	2.50.0	3.03.0	2.32.0	2.52.0	2.24.0
Дундаж		3.10.0	3.02.0	2.52.0	2.46.0	3.30.0	3.10.0	3.22.0	2.52.0	3.12.0	2.45.0
Дунджаас доогуур		3.30.0	3.22.0	3.12.0	3.08.0	3.50.0	3.30.0	3.42.0	3.10.0	3.30.0	3.07.0
Тааруу		4.00.0	3.52.0	3.42.0	3.36.0	4.20.0	4.00.0	4.06.0	3.40.0	3.50.0	3.36.0

Бол- түвшин	Уян хатан: БӨХИЙЛТ (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)										
	Бага боловсрол (6-10 нас)	Хөдөлгөөний үйлдлийг хамгийн их далайцаар гүйцэтгэх чадавх буюу уян хатны үзүүлэлт 6-10 насанд ойролцоо буюу 1-2 см хэлбэлзэлтэй байна. Гэхдээ судалгааны үр дүнгээс 10 настай хөвгүүдэд уян хатны үзүүлэлт буурах байдал ажиглагдсан ба суугаа байдлаас бөхийхөд гарын хуруу нь өлмийдөө хүрэхгүй сурагч байсныг онцгой анхаарах шаардлагатай.									
Шалгуур үзүүлэлт		6 нас		7 нас		8 нас		9 нас		10 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Дээд		13	12	14	12	14	12	15	13	15	14
Дунджаас дээгүүр		10	9	10	9	10	9	10	10	12	11
Дундаж		7.5	6	7	6	7	6	7.5	7	8	8
Дунджаас доогуур		4	3	4	3	4	3	4	4	4	4
Доод		2	1	2	1	2	1	2	2	2	2

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Цогц чадамж 1. Бие бялдрын хөгжил (11-14 нас)

Хүйс	Биеийн өндөр (см)								
	Биеийн өндрийн үзүүлэлт жилд охидууд 11-12 насанд 7см, 13-14 насанд 6 см өссөн, хөвгүүд 11-12 насанд 5см, 13-14 насанд 5 см-ээр өссөн байна. 11-12 насанд охидын өндрийн үзүүлэлт хөвгүүдийнхээс түрүүлж 13-14 хөвгүүдийн биеийн өсөлт эрчимжиж охидыг гүйцэж түрүүлнэ. Энэ нь бие бялдрын эрчимтэй өсөлтийн гурав дахь үетэй холбоотой байна.								
Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур	11 нас		12 нас		13 нас		14 нас	
	үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээш	153.0	149.0	160.0	157.8	167.0	167.0	169.0	170.0
	Дунджаас дээгүүр	150.0	146.0	155.0	151.0	160.0	160.0	163.0	166.0
	Дундаж	143.0	141.0	151.0	146.0	154.0	154.0	157.0	160.0
	Дунджаас доош	138.0	138.0	146.0	141.0	148.0	148.0	148.0	154.0
	Доод	133.0	132.0	142.0	136.0	142.0	142.0	142.0	148.0

Хүйс	Биеийн жин (кг)								
	Биеийн жин жилд охид 11-12 насанд 6 кг, 12-13 насанд 4кг, 13-14 насанд 3 кг аар нэмэгдсэн, хөвгүүд 11-12 насанд 3.5 кг, 12-13 насанд 4кг, 13-14 насанд 6 кг аар нэмэгдсэн байна. 11-16 нас эрчимтэй хөгжлийн гурав дахь үе учир хөвгүүдийн биеийн жин нилээд өндөр хэмжээгээр нэмэгдсэн байна.								
Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур/нас	11 нас		12 нас		13 нас		14 нас	
	үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	47.0	44.0	53.0	49.0	58.0	54.0	61.0	61.0
	Дунджаас дээгүүр	41.0	38.0	48.0	43.0	53.0	48.0	57.0	55.0
	Дундаж	37.0	36.0	43.0	39.0	47.0	43.0	50.0	49.0
	Дунджаас доогуур	31.0	32.0	38.0	33.0	42.0	36.0	44.0	43.0
	Сул	28.0	29.0	34.0	31.0	38.0	33.0	40.0	40.0

Суурь боловсрол (11-14 нас)	Цээжний тойрог (см)								
	Дунд ангийн 11 -14 насны хүүхдүүдийн бие махбодийн өсөлт хөгжил болон бэлгийн бойжилт хурдсана. Охидын цээжний тойрог жилд 2.4 – 5.3 см-р нэмэгддэг, бол хөвгүүдийн цээжний тойрог 2.6 – 3.7 см нэмэгддэг байна.								
	Шалгуур/ нас	11 нас		12 нас		13 нас		14 нас	
	үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	77.0	75.0	81.0	78.0	85.0	82.0	88.0	86.0
	Дунджаас дээгүүр	73.0	70.0	78.0	74.0	81.0	78.0	84.0	81.0
	Дундаж	68.0	67.0	74.0	70.0	77.0	73.0	79.0	76.0
	Дунджаас доогуур	64.0	64.0	70.0	66.0	73.0	68.0	75.0	72.0
Сул	62.0	62.0	66.0	64.0	71.0	65.0	72.0	68.0	

Суурь боловсрол (11-14 нас)	Баруун, Зүүн гарын хүч																
	Дунд ангийн 11 - 14 насны хүүхдүүдийн булчингийн хөгжил сайжирч, охид гарын сарвууны булчингийн хүч 11 - 13 насанд жилд 3.5 кг хүртэл, хөвгүүд 11-13 насанд жилд 2.2 кг, 13 - 14 насанд жилд – 5.5 кг нэмэгддэг байна. Баруун гарын атгах хүч, зүүн гарын сарвууны атгах хүчнээс 1 - 2 кг илүү байна.																
	нас	11 нас				12 нас				13 нас				14 нас			
	үзүүлэлт	Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд	
		Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З
	Дээд	20.0	19	22.0	21	25.0	23	25.0	24	29.0	26	30.0	29	30.0	28	36.0	34
	Дунджаас дээгүүр	18.0	16	20.0	18	21.0	20	21.0	20	25.0	22	25.0	25	26.0	25	31.0	29
	Дундаж	14.3	13	16.4	15	17.8	16	18.9	17	20.7	19	21.1	20	22.3	20	26.6	25
Дунджаас доогуур	11.0	10	12.0	12	14.0	13	15.0	14	18.0	15	16.5	16	19.0	16	21.0	20	
Сул	8.0	9	10.0	10	11.0	11	13.0	11	15.0	12	12.0	12	15.0	13	18.0	18	

Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур	Уушгины амьсгал гаргах хурд							
		12 наснаас эхлэн 16 нас хүртэл уушги эрчимтэй томрон хөгжих бөгөөд уушгины амьдралын багтаамж, уушгины амьсгал гаргах дээд хурд зэрэг физиологийн үзүүлэлтүүд нэмэгдэж, 13 -14 нас гэхэд насанд хүрсэн хүний үзүүлэлтэд хүрдэг							
		11 нас		12 нас		13 нас		14 нас	
	хүйс	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	300.0	340.0	350.0	370.0	400.0	430.0	400.0	460.0
	Дунджаас дээгүүр	260.0	300.0	310.0	250.0	350.0	250.0	350.0	300.0
Дундаж	228.4	255.7	272.6	291.6	298.9	310.3	311.6	368.0	
Дунджаас доогуур	190.0	255.7	220.0	291.6	250.0	310.3	250.0	368.0	
Сул	150.0	220.0	200.0	330.0	201.0	360.0	210.0	430.0	

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Цогц чадамж 2. Бие бялдрын бэлтгэлжилт (11-14 нас)

Бол-түвшин	Хурд: 50 м ГҮЙЛТ (с) (Босоо гараанаас 50 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)								
	Суурь боловсрол (11-14 нас)	11 нас		12 нас		13 нас		14 нас	
Шалгуур үзүүлэлт		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Бидний судалгааны дүнгээс харвал 50 м зайд гүйх хурдны үзүүлэлт суурь боловсролын түвшинд 11 насанд нэлээд өндөр байсан ба охидын хурд 12 насанд буурч, 13-14 насанд тогтвортой байсан. Хөвгүүдийн хувьд энэ үзүүлэлт 12-13 насанд ялимгүй сайжирсан. Суурь боловсролын түвшний бүх насанд хөвгүүд нь охидоос илүү хурдтай байгаа нь харагдсан.									
Дээд		8.5	8.2	9.4	8.0	9.0	7.8	8.8	7.7
Дунджаас дээгүүр		8.8	8.6	9.8	8.3	9.3	8.0	9.2	8.0
Дундаж		9.5	9.2	10.2	9.0	10.0	8.8	10.0	8.8
Дунджаас доогуур		11.0	9.7	10.8	9.6	10.7	9.3	10.5	9.2
Доод	12.0	11.0	11.8	10.6	11.6	10.0	11.3	9.8	

Бол- түвшин	Гарын хүч: ГАР ДЭЭР СУНИАЛТ (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ суниалтын тоог тоолно)								
Суурь боловсрол (11-14 нас)	Суурь боловсролын түвшинд хүүхдийн гарын хүч сургуулийн бага насны үеийнхээс сайжрах боловч 11 наснаас 14 нас хүртлэх хугацаанд хүч огцом нэмэгдэхгүй байна. Гэхдээ гарын хүч маш сайн сурагчдын гар дээрээ суниах тоо нь дундаж үзүүлэлтээс 8-11 удаагаар илүү байгаа нь нэг ижил насны сурагчдад хүчний ялгаа их байгааг харуулна.								
	Шалгуур үзүүлэлт	11 нас		12 нас		13 нас		14 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Маш сайн	20	27	22	29	22	30	23	31
	Дунджаас дээгүүр	16	23	17	24	18	25	18	26
	Дундаж	12	17	13	19	13	19	13	20
	Дунджаас доогуур	7	12	7	13	8	14	8	15
	Сул	3	5	3	7	4	7	4	8

	Хөлийн хүч: БАЙРНААС УРТАД ХАРАЙЛТ (см) (Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно)								
Суурь боловсрол (11-14 нас)	Хөлийн хүч буюу байрнаас уртад харайх охидын дундаж үзүүлэлт 11-12 насанд 6.3 см, 12-13 насанд 8 см-ээр ахисан бол 14 насанд буурах байдал (-8 см) ажиглагдсан. Харин хөвгүүдийн хувьд энэ үзүүлэлт 11-12 насанд 10 см, 13 насанд хамгийн багаар буюу 4 см-ээр нэмэгдсэн ба 14 насанд хамгийн их буюу 18.3 см-ээр сайжирсан.								
	Шалгуур үзүүлэлт	11 нас		12 нас		13 нас		14 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	161	171	163	178	167	194	170	210
	Дунджаас дээгүүр	145	159	153	166	162	176	164	196
	Дундаж	132	148	137	155	145	159	147	177
	Дунджаас доогуур	119	135	125	144	129	146	132	162
	Доод	103	123	113	135	120	130	123	148

		Хөдөлгөөний эвсэл: 3x10 м ГҮЙЛТ (с) (10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ)							
Суурь боловсрол (11-14 нас)	Охидын хувьд 10-12 насанд хөдөлгөөний эвслийн хөгжилд мэдэгдэм ялгаа ажиглагдаагүй бөгөөд 13 насанд энэ үзүүлэлт ялимгүй буурч, 14 насанд бага зэрэг (0.3 с) ахисан. Хөвгүүдийн хувьд хөдөлгөөний эвслийн хөгжил 11-13 насанд жигд явагдаж байснаа 14 насанд дундаж үзүүлэлтэд нэлээд ахиц (0.7 с) ажиглагдсан байна. Суурь боловсролын түвшний бүх насанд хөдөлгөөний эвслийн үзүүлэлтээр хөвгүүд охидоос илүү байсан.								
	Шалгуур үзүүлэлт	11 нас		12 нас		13 нас		14 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	8.4	8.3	8.4	8.0	8.3	7.8	8.2	7.6
	Дунджаас дээгүүр	9.0	8.6	8.9	8.5	8.8	8.3	8.6	8.1
	Дундаж	10.0	9.7	9.8	9.5	9.7	9.3	9.6	9.0
	Дунджаас доогуур	10.5	10.0	10.3	9.9	10.0	9.7	10.0	9.2
	Доод	11.5	11.0	11.3	10.9	11.0	10.7	10.8	10.3

Бол- түвшин		Тэсвэр: 500 м ГҮЙЛТ (мин) (Босоо гараанаас 500 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)							
Суурь боловсрол (11-14 нас)	Хүний нас нэмэгдэхийн хэрээр тэсвэр сайжирдаг болохыг олон судалгааны үр дүн харуулдаг. Гэвч бидний судалгаагаар 500 м зайг гүйж туулах ерөнхий тэсвэр 11 насанд охид ба хөвгүүдэд хамгийн сайн үзүүлэлт ажиглагдсан. Ерөнхий тэсвэрийн чадавхаар суурь боловсролын түвшний бүх насанд хөвгүүд, охидоос нэлээд дээгүүр үзүүлэлттэй байсан ба тэд 500 м зайг дунджаар 13-21 с богино хугацаанд туулж байна.								
	Шалгуур үзүүлэлт	11 нас		12 нас		13 нас		14 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	2.16.0	2.00.0	2.13.0	1.55.0	2.10.0	1.50.0	2.06.0	1.46.0
	Дунджаас дээгүүр	2.36.0	2.16.0	2.33.0	2.10.0	2.30.0	2.02.0	2.26.0	2.00.0
	Дундаж	2.56.0	2.35.0	2.53.0	2.30.0	2.50.0	2.16.0	2.48.0	2.10.0
	Дунджаас доогуур	3.26.0	2.55.0	3.23.0	2.50.0	3.15.0	2.32.0	3.10.0	2.28.0
	Доод	3.56.0	3.15.0	3.53.0	3.10.0	3.40.0	3.00.0	3.30.0	2.55.0

Бол- түвшин	Уян хатан: БӨХИЙЛТ (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)								
	Суурь боловсрол (11-14 нас)	Суурь боловсролын түвшинд хүүхдийн уян хатны хөгжлийн үзүүлэлт тогтвортой хэмжээнд байсан. Хүүхдийн нас бага байх тусам булчингийн уян налархай байдал илүү байх зүй тогтолтой боловч 11-14 насанд уян хатны үзүүлэлт жилд 1-2 см-ээр ахиж байна. Энэ нь уян хатны дасгалыг гүйцэтгэхэд булчингийн хүч нөлөөлдөгтэй холбоотой гэж үзэж байна. Дунд ангийн охид уян хатны чадавхын хөгжлөөр бүх насанд хөвгүүдээс илүү үзүүлэлттэй байна.							
Шалгуур үзүүлэлт		11 нас		12 нас		13 нас		14 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Дээд		16	14	18	14	19	16	20	18
Дунджаас дээгүүр		13	10	14	11	15	11	17	13
Дундаж		9	7	9	7	10	8	11	9
Дунджаас доогуур		4	3	4	3	5	4	6	5
Доод		3	2	3	2	2	3	3	2

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Цогц чадамж 1. Бие бялдрын хөгжил (15-17 нас)

Бүрэн дунд (15-17 нас), Мэргэжлийн болон Дээд	Биеийн өндөр (см)							
	Охидын өндрийн өсөлт 15 -16 насанд 1 см нэгдэж байхад, хөвгүүдийн өндөр 3.6 - 4.6 см нэмэгдэнэ, харин охидын биеийн өсөлт хөгжилтийн процесс 16 наснаас, хөвгүүдийн биеийн өсөлт хөгжил 17 - 18 наснаас эхлэн удаашрах бөгөөд өндрийн өсөлт, ясжилтын процесс 17 -18 насанд үндсэндээ дуусна.							
Шалгуур үзүүлэлт	15 нас		16 нас		17 нас		18-21 нас	
	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
Дээш	163.0	171.0	167.0	175.0	163.0	173.0	167.0	176.0
Дунджаас дээш	161.0	166.0	162.0	172.0	161.0	171.0	162.0	173.0
Дундаж	157.0	165.0	158.0	168.0	157.0	169.0	158.0	169.0
Дунджаас доош	153.0	155.0	153.0	165.0	153.0	165.0	153.4	166.0
Доод	150.0	148.0	150.0	160.0	150.0	160.0	150.0	162.0

Бүрэн дунд (15-17 нас), Мэргэжлийн болон Дээд боловсрол (18-21 нас)	Биеийн жин (кг)								
	Биеийн жин жилд охид, эмэгтэйчүүдийн хувьд 15-16 насанд 3 кг, 16-17 насанд 1 кг, 17-18 насанд 2 кг –аар нэмэгдсэн, хөвгүүдийн хувьд 15-16 насанд 4 кг, 16-17 насанд 3 кг, 17-18 насанд 2 кг –аар нэмэгдсэн байна. Охидын биеийн жин 15 -17 насанд тогтворжиж, хөвгүүдийн биеийн жин жилд 1-2 кг нэмэгддэг. 18-21 насанд эмэгтэйчүүд, залуучуудын биеийн жингийн үзүүлэлт тогтворждог байна.								
	Шалгуур	15 нас		16 нас		17 нас		18-21 нас	
	үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	59.0	61.0	65.0	67.0	65.0	67.0	67.0	73.0
	Дунджаас дээгүүр	56.0	55.0	57.0	61.0	58.0	61.0	61.0	65.0
	Дундаж	52.0	54.0	54.0	57.0	55.0	60.0	57.0	62.0
	Дунджаас доогуур	48.0	43.0	49.0	53.0	49.0	53.0	51.0	57.0
Сул	44.0	40.0	46.0	49.0	45.0	49.0	46.0	53.0	

Бүрэн дунд (15-17 нас), Мэргэжлийн болон Дээд боловсрол (18-21 нас)	Цээжний тойрог								
	15-16 насны охидын цээжний тойрог жилд 1 – 3 см - р нэмэгддэг. 15-16 насны хөвгүүдийн цээжний тойрог жилд 1 – 6 см - р нэмэгддэг. 18-21 насанд эмэгтэйчүүд, залуучуудын цээжний тойрог үзүүлэлт тогтворждог байна.								
	Шалгуур	15 нас		16 нас		17 нас		18-21 нас	
	үзүүлэлт	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд	Охид	Хөвгүүд
	Дээд	87.0	86.0	90.0	90.0	90.0	90.0	91	91
	Дунджаас дээгүүр	83.0	81.0	86.0	86.5	86.0	86.5	87	87
	Дундаж	79.6	76.8	82.2	83.1	82.9	83.1	84	84
	Дунджаас доогуур	77.0	72.0	78.0	79.0	78.0	79.0	80	80
Сул	73.0	68.0	74.0	76.0	76.0	76.0	77	77	

Бүрэн дунд (15-17 нас), Мэргэжлийн болон Дээд боловсрол (18-21 нас)	Баруун, зүүн гарын атгах хүч																	
	Ахлах ангийн 15 - 17 насны хөвгүүдийн баруун, зүүн гарын атгах хүч 2-4 кг зөрүүтэй байна. 15 - 17 насны охидын баруун, зүүн гарын атгах хүч 2 кг зөрүүтэй байна. 18 - 21 насны эмэгтэйчүүдийн баруун, зүүн гарын атгах хүч 2 кг зөрүүтэй, залуучуудын үзүүлэлт ялгаагүй байна.																	
	Шалгуур		15 нас				16 нас				17 нас				18-21 нас			
	үзүүлэлт		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд	
			Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З
	Дээд		30	28	36	34	32	30	45	40	32	28	45	40	34	32	48.5	48.0
	Дунджаас дээгүүр		27	26	31	29	29	26	40	37	28	24	40	37	31	28	44.0	43.0
	Дундаж		24	22	27	25	25	23	36	32	25	23	36	32	27	25	39.2	39.1
Дунджаас доогуур		20	19	21	20	21	20	30	29	20	19	30	29	23	22	34.5	34.0	
Сул		17	15	18	18	18	17	28	24	18	14	28	24	19	18	29.0	30.0	

Бүрэн дунд (15-17 нас), Мэргэжлийн болон Дээд боловсрол (18-21 нас)	Уушгины амьсгал гаргах хурд																	
	15 наснаас 17 нас хүртэл уушгины амьдралын багтаамж, уушгины амьсгал гаргах дээд хурд зэрэг физиологийн үзүүлэлтүүд үргэлжлэн нэмэгддэг.																	
	Шалгуур		15 нас				16 нас				17 нас				18-21 нас			
	үзүүлэлт		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд		Охид		Хөвгүүд	
			Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З	Б	З
	Дээд		403.0		460.0		410.0		550.0		420.0		550.0		421		557.5	
	Дунджаас дээгүүр		360.0		430.0		375.0		490.0		380.0		490.0		385		490.5	
	Дундаж		318.5		368.0		319.6		424.8		324.7		424.8		328		435.6	
Дунджаас доогуур		270.0		300.0		270.0		360.0		280.0		360.0		288		422.5		
Сул		240.0		260.0		250.0		300.0		260.0		300.0		268		397.5		

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Хөгжлийн дэд бүрдэл 2. Бие бялдрын бэлтгэлжилт (15-17 нас)

Бол- түвшин	Хурд: 50 м ГҮЙЛТ (с) (Босоо гараанаас 50 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)						
Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Хүч нэмэгдэхийн хэрээр хурд дагалдан хөгжих боломжтой,						
	Шалгуур үзүүлэлт	15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	8.6	7.8	8.5	7,5	8.4	7.3
	Дунджаас дээгүүр	9.0	8.2	8.8	8,0	8.6	7.5
	Дундаж	10.0	8.6	9.9	8,5	9.8	8.3
	Дунджаас доогуур	10.5	9.2	10.3	9.0	10.3	8.8
Доод	11.3	9.8	11.2	9.5	11.2	9.4	

Бол- түвшин	Гарын хүч: ГАР ДЭЭР СУНИАЛТ (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ суниасан тоог тоолно)						
Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Хүүхдийн нас нэмэгдэхийн хэрээр гарын хүч нэмэгдэнэ. Ахлах ангийн бүх насанд хөвгүүд охидоос гарын хүчээр илүү байна.						
	Шалгуур үзүүлэлт	15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Маш сайн	20	31	22	35	25	38
	Дунджаас дээгүүр	18	27	19	31	20	33
	Дундаж	14	20	15	24	16	26
	Дунджаас доогуур	8	16	9	18	10	19
Сул	3	9	4	10	4	10	

Бол- түвшин	Хөлийн хүч: БАЙРНААС УРТАД ХАРАЙЛТ (см)						
	(Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно)						
Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Ахлах ангийн хөвгүүдийн хөлийн хүч нас ахих тутам сайжирч байна. Гэхдээ 16 насанд байрнаас уртад харайлтын дундаж үзүүлэлт 26.6 см нэмэгдсэн боловч 17 насанд ердөө 1.3 см нэмэгдэж байгааг тогтоосон. Анги ахих тутам охид, хөвгүүдийн хөлийн хүчний ялгаа ихэсч, хөвгүүд охидоос дунджаар 15 насанд 30.2 см, 16 насанд 58.2 см, 17 насанд 57.8 см хол харайсан байна.						
	Шалгуур үзүүлэлт	15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	175	215	178	230	180	240
	Дунджаас дээгүүр	156	198	160	220	164	225
	Дундаж	150	180	152	195	155	205
	Дунджаас доогуур	135	165	138	178	140	188
Доод	126	150	128	160	130	170	

Бол- түвшин/нас	Хөдөлгөөний эвсэл: 3x10 м ГҮЙЛТ (с)						
	(10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ. Сурагч бүр 2 удаа гүйх ба аль сайн үзүүлэлтийг тооцно)						
Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Хөвгүүдийн энэ үзүүлэлтэд 15 насанд өөрчлөлт ажиглагдаагүй ба 16 насанд 0.3 с ахицтай байсан боловч 17 насанд 0.1 с удааширсан байна. Орон зайд биеэ хурдтай эргүүлж чиглэлээ өөрчлөн гүйх хөдөлгөөний эвслийн үзүүлэлт энэ насны сурагчдын хурдны үзүүлэлтээс хамааралтай байна.						
	Шалгуур үзүүлэлт	15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
	Дээд	8.0	7.5	8.0	7.3	8.0	7.2
	Дунджаас дээгүүр	8.5	8.0	8.4	7.8	8.3	7.6
	Дундаж	9.8	8.8	9.5	8.5	9.5	8.4
	Дунджаас доогуур	10.0	9.0	9.9	9.0	9.8	8.8
Доод	11.0	10.2	10.7	10.0	10.6	9.8	

Бол- түвшин	Тэсвэр: 1000 м ГҮЙЛТ (мин) (Босоо гараанаас 1000 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)						
	Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Хүүхдийн нас өсөхийн хэрээр ерөнхий тэсвэр сайжрах ёстой боловч бидний судалгаагаар 15-17 насны охид, хөвгүүдэд энэ үзүүлэлт эсрэг үр дүнтэй байсан. Ялангуяа 15-16 насанд охидын тэсвэрийн чадавх нэлээд буурч байна. 17 насанд бага зэргийн өсөлт ажиглагдсан боловч энэ нь 15 насны үзүүлэлтээс ч доогуур байна.					
Шалгуур үзүүлэлт		15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Дээд		5.30.0	4.50.0	5.28.0	4.40.0	5.26.0	4.30.0
Дунджаас дээгүүр		5.50.0	5.10.0	5.48.0	5.00.0	5.46.0	4.50.0
Дундаж		6.10.0	5.30.0	6.08.0	5.20.0	6.06.0	5.10.0
Дунджаас доогуур		6.35.0	5.55.0	6.33.0	5.45.0	6.31.0	5.35.0
Доод	7.10.0	6.30.0	7.08.0	6.20.0	7.07.0	6.10.0	

Бол- түвшин	Уян хатан: БӨХИЙЛТ (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)						
	Бүрэн дунд боловсрол (15-18 нас)	Уян хатны чадавх нас нэмэгдэхийн хэрээр буурах магадлалтай байдаг. Бидний судалгаагаар 15-17 насанд уян хатны үзүүлэлт тогтвортой байсан. Ахлах ангийн охид хөвгүүдээсээ илүү уян байсан нь бөхийлтийн дасгалын дундаж үзүүлэлт 2 см, дээд үзүүлэлт 3-4 см илүү байгаагаас харагдана. Бөхийлтийн дасгалын дунджаас доогуур ба доод үзүүлэлт буурсан байгааг анхаарч, эдгээр түвшинг дээшлүүлэх шаардлагатай.					
Шалгуур үзүүлэлт		15 нас		16 нас		17 нас	
		охид	хөвгүүд	охид	хөвгүүд	охид	хөвгүүд
Дээд		22	18	22	19	22	19
Дунджаас дээгүүр		17	13	17	15	17	15
Дундаж		12	10	13	11	13	11
Дунджаас доогуур		7	5	8	6	9	6
Доод	4	3	4	3	4	3	

Хөгжлийн бүрдэл 1. Бие бялдар

Хөгжлийн дэд бүрдэл 2. Бие бялдрын бэлтгэлжилт (18-21 нас)

Бол- түвшин/нас	Хурд: 50 м ГҮЙЛТ (с) (Босоо гараанаас 50 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)								
	Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	18 насны эмэгтэйчүүдийн хурд 17 насны түвшингээс нэлээд буурсан буюу 50 м зайд гүйх дундаж үзүүлэлт 1 с-ээр муудсан байна. Эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсний залуучуудын хурдтай гүйх дээд түвшний үзүүлэлт 18 насанд хамгийн ихээр сайжирсан ба 19-20 насанд тогтворжиж, 21 насанд буурсан.							
Шалгуур үзүүлэлт		18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Дээд		9.0	7.2	8.8	7.0	9.0	7.0	9.0	7.2
Дунджаас дээгүүр		9.6	7.6	9.4	7.5	9.6	7.4	9.6	7.6
Дундаж		10.0	8.2	10.0	8.2	10.2	8.0	10.2	8.0
Дунджаас доогуур		10.8	8.8	10.8	8.8	11.4	8.6	11.4	8.6
Доод	12.0	9.5	12.0	9.5	12.0	9.5	12.0	9.5	

Бол- түвшин	Гарын хүч: ГАР ДЭЭР СУНИАЛТ (удаа) (Тулж хэвтсэн байдлаас 30 сек гар дээрээ сунисан тоог тоолно)								
	Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	Эмэгтэйчүүдийн гарын хүчний үзүүлэлт буюу 30 гар дээр суниах тоо 18-19 насанд бага зэрэг буюу 2 удаагаар нэмэгдээд 20-21 насанд бууралт ажиглагдсан. Эрэгтэйчүүдийн гарын хүчний үзүүлэлт 18-20 насанд сайжирсан боловч 21 насанд тогтворжсон байна.							
Шалгуур үзүүлэлт		18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Маш сайн		21	35	23	38	20	44	19	42
Дунджаас дээгүүр		15	31	16	33	15	36	15	36
Дундаж		12	24	14	26	12	30	12	30
Дунджаас доогуур		8	19	9	20	6	25	5	25
Сул	3	10	3	10	3	14	3	14	

Бол- түвшин	Хөлийн хүч: БАЙРНААС УРТАД ХАРАЙЛТ (см)								
	(Байрнаас хоёр хөлөөр түлхэн уртад харайсан зайг хэмжинэ. 3 удаагийн харайлтын хамгийн холыг тооцно)								
Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	Эмэгтэй суралцагчдын байрнаас уртад харайх хүч 18-21 насанд жил бүр буурсан үзүүлэлттэй байна. Эрэгтэй ба эмэгтэй суралцагчдын байрнаас уртад харайх дундаж үзүүлэлт маш их зөрүүтэй байгаа нь тэдний хөлийн хүчний ялгааг харуулна.								
	Шалгуур үзүүлэлт	18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
	Дээд	180	260	185	265	180	265	180	265
	Дунджаас дээгүүр	165	250	172	255	165	255	165	255
	Дундаж	150	235	150	240	145	245	145	245
	Дунджаас доогуур	130	220	132	230	130	235	130	235
Доод	120	210	120	220	120	225	120	225	

Бол- түвшин	Хөдөлгөөний эвсэл: 3x10 м ГҮЙЛТ (с)								
	(Гарааны шугам дээрх 2 ширхэг шоог нэг нэгээр нь зөөж, 10 м зурвасын хооронд 3 удаа гүйсэн хугацааг хэмжинэ)								
Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	Бидний судалгааны дүнгээс залуучуудын насанд орон зайд биеэ хурдтай шилжүүлэн, хөдөлгөөнөө удирдах эвслийн чадавхын үзүүлэлт буурах байдал ажиглагдсан. Энэ насны эрэгтэйчүүдийн хувьд 18-20 насанд хөдөлгөөний эвсэл сайжирсан бол 21 насанд буурах байдал ажиглагдаж байна. Эрэгтэй, эмэгтэй залуучуудын хөдөлгөөний эвсэлд ялгаа их байгаа ба бүх насанд эрэгтэйчүүд илүү үзүүлэлттэй байна.								
	Шалгуур үзүүлэлт	18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
	Дээд	8.4	7.0	8.4	6.8	8.8	6.6	8.8	7.0
	Дунджаас дээгүүр	9.0	7.5	9.0	7.4	9.2	7.2	9.2	7.5
	Дундаж	9.4	8.3	9.4	8.1	9.5	7.9	9.5	8.0
	Дунджаас доогуур	10.0	8.8	10.0	8.7	10.2	8.5	10.2	8.5
Доод	11.0	9.5	11.0	9.4	11.0	9.2	11.0	9.2	

Бол- түвшин	Тэсвэр: 1000,1500 м ГҮЙЛТ (мин) (Босоо гараанаас 1000,1500 м зайд гүйсэн хугацааг хэмжинэ)								
	Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	Бидний судалгаагаар залуучуудын насны эмэгтэйчүүдийн тэсвэр 19 насанд бага зэрэг сайжирсан бол 20-21 насанд буурч байна.Энэ нь тэдний тэсвэрийг сайжруулах ба бууруулахгүй байх зорилготой биеийн тамирын хичээл, хичээлийн бус хэлбэрийн ажлууд цөөрч, заримдаа бүр огт хийгдэхгүй байгаатай холбоотой юм.1000 м зайг гүйж туулах хугацааны хувьд 18-21 насны эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс нэлээд сайн үзүүлэлттэй байгаа нь эрэгтэйчүүд илүү тэсвэртэй болохыг харуулж байна.							
Шалгуур үзүүлэлт		18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Дээд		5.20.0	4.00.0	5.10.0	3.56.0	5.10.0	3.52.0	5.10.0	3.52.0
Дунджаас дээгүүр		5.40.0	4.20.0	5.30.0	4.16.0	5.40.0	4.12.0	5.40.0	4.12.0
Дундаж		6.00.0	4.40.0	6.00.0	4.36.0	6.10.0	4.32.0	6.10.0	4.32.0
Дунджаас доогуур		6.30.0	5.00.0	6.30.0	4.56.0	6.40.0	4.50.0	6.40.0	4.50.0
Доод		7.00.0	5.30.0	7.00.0	5.26.0	7.10.0	5.20.0	7.10.0	5.20.0

Бол- түвшин	Уян хатан: БӨХИЙЛТ (см) (Хөлөө жийж суусан байдлаас бөхийж, гарын хурууг өлмийнөөс цааш гаргасан зайг хэмжинэ)								
	Дээд ба мэргэжлийн боловсрол (18-21 нас)	18-21 насны эмэгтэйчүүдийн хувьд уян хатны үзүүлэлт буураагүй, тогтвортой түвшингээ хадгалах боломжтой байгаа нь судалгаанаас харагдсан. Энэ насанд уян хатныг их хэмжээгээр хөгжүүлэх шаардлагагүй бөгөөд залуучуудын өдөр тутмын амьдралд хэрэгцээт хэмжээнд хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлж болно.							
Шалгуур үзүүлэлт		18 нас		19 нас		20 нас		21 нас	
		эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
Дээд		23	20	23	20	21	20	21	20
Дунджаас дээгүүр		19	16	19	17	17	16	17	16
Дундаж		14	11	14	12	13	11	13	11
Дунджаас доогуур		10	7	10	8	10	7	9	7
Доод		6	4	7	5	7	4	6	4

ХОЁР. 6-21 настай хүүхэд, залуучуудын танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт

Танин мэдэхүйн хөгжил гэдэг нь мэдээллийг хүлээн авч боловсруулах, хадгалан сэргээн санах, сэтгэн бодож учир шалтгаан, зүй тогтлыг олох болон хэл ярианы чадвар юм. Хүртэхүй, ой тогтоолт, анхаарал, сэтгэхүй, хэл яриа танин мэдэхүйн үйл явцыг бүрдүүлэгч гол элементүүд. Хүний танин мэдэхүйн хөгжлийн шалгуур нь мэдээллийг хүлээж авч боловсруулах хурд, бие даан сэтгэж юмсын учир шалтгаан зүй тогтлыг олох чадвар, оновчтой байдал, мэдээллийн гол ба гол бус шинжийг ялгах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хийсвэрлэн ойлгох чадвар зэрэг юм. Танин мэдэхүйн хөгжил нь өөрийн гэсэн зүй тогтолтой байх бөгөөд ялангуяа хэл ярианы хөгжилд гадаад хүчин зүйлийн нөлөөлөл байдаг хэдий ч сэтгэхүйн хөгжилтэй холбоотойгоор нас болгон нь ерөнхий онцлогийг агуулдаг байна.

Хүүхдийн танин мэдэхүйн хөгжил нь хүүхдийн өөрийнх нь үйл ажиллагаа, насанд хүрэгчдийн дэмжлэг, сургалтын нөлөөгөөр явагддаг. Танин мэдэхүйн хөгжлийн шалгуур нь бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшингээр мэдээллийг хүртэх, хүлээн авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх ба хэл ярианы чадвар гэсэн хоёр бүрдэлтэй.

Мэдээллийг хүртэх, хүлээн авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх бүрдэл нь *хүртэхүй, ой тогтоолт, анхаарал, сэтгэхүйн үйл явцыг* агуулна. Хэл яриаг эзэмшинэ гэдэг нь эцсийн дүндээ хүнд үгийн утга бий болох буюу ухагдахуун төлөвшихийг хэлнэ. Үгийн утгын тогтолцоо нь нэгтгэн дүгнэх үйлийн тусламжтайгаар тодорхой үе шатттайгаар төлөвшдөг. (Л.С Выготский, 1962, Ж.Пиаже 1969, Брунер 1977, Давыдов, 1972)

Хэл ярианы хөгжлийн бүрдэл нь *ухагдахуун төлөвшил, ярих чадвараас* бүрдэж байна. *Танин мэдэхүйн хөгжлийн шалгуур үзүүлэлт нь* бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд хамрагдах насны хүүхэд, залуучуудын танин мэдэхүйн хөгжлийн хүрэх түвшин, хэмжих үзүүлэлтээс бүрдэнэ.

Хүний хөгжлийн шалгуур, үзүүлэлтийн энэхүү бүрдэл нь 6-21 насны хүүхэд залуучуудын хөгжлийг хөндлөнгөөс дэмжих, хүүхэд, залуучууд өөрийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж- Мэдээллийг хүртэж, хүлээж авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (6-10 нас)

Бол- түвшин/ нас	1. Хүртэхүй			
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Бага боловсрол (6-10 нас)		6-7 нас		8-10 нас
	Танил юмсын хэлбэр, хэмжээ, өнгө, бүрэлдэхүүн зэргийг хүртэх чадвартай байх.	5-7 хүртэлх тооны юмсын ялгаатай болон төстэй шинж, дутуу зүйлийг богино хугацаанд нэрлэнэ.	Юмсын хэлбэр, хэмжээ, тоо, байрлал зэргийг хүртэх чадвартай байх.	10 гаруй онцлог ялгаатай шинжүүдээс 5-9 хүртэлхийг нэрлэнэ.
	2. Анхаарал			
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
		6-7 нас		8-10 нас
	Анхаарлаа зориудаар төвлөрүүлэн үйл ажиллагаа гүйцэтгэх чадвартай байх	Хэлбэр, дүрс, тоо, тэмдэгт бүхий мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах чадвартай.	Анхаарлаа зориудаар төвлөрүүлэн ажиллах чадвар нэмэгдэнэ.	Хэлбэр, дүрс, энгийн тоо, тэмдэгтээс гадна оюуны энгийн үйлдлийг анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэх чадвартай байна.
	3. Ой тогтоолт			
Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт	
	6-7 нас		8-10 нас	
Энгийн дүрс, зураг, өөрт танил үгс, хэллэгийг	Энгийн дүрс, зураг, танил үгсийг хараад, сонсоод тогтоон сэргээн санах болон хялбар, үлгэр, өгүүллэг	Сэтгэхүйн хөгжилтнй уялдан хүүхдийн зориудаар мэдээллийг тогтоох чадвар сайжирна.	Хоорондоо холбоо багатай тоо, дүрс, бодит утгатай үгийг хараад, сонсоод, сэргээн санах чадвартай байх.	

	хялбар тогтоох чадвартай.	зэргийг утгаар нь тогтоон сэргээх чадвартай.		Байнга хэрэглэдэггүй үг, хэллэгтэй ердийн үйл явдлыг агуулсан өгүүллэг, үлгэр зэргийг тогтоон сэргээн санах чадвартай байх
4. Сэтгэхүй				
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
	Юмсыг бодитоор мэдэрч, харсны үндсэн дээр учир шалтгаан, зүй тогтлыг нь таних чадвартай.	Энгийн юмсыг гадаад шинж, төрх байдлаар нь харьцуулах, ангилах чадвартай байхаас гадна, өдөр тутмын амьдралын юмс үзэгдлийн талаарх ойлголттой байх; Бодитоор юмсыг харж учир шалтгаан зүй тогтлыг таних, дуурайн үйлдэх чадвартай байх.	Юмсыг бодитоор мэдэрч, харсны үндсэн дээр учир шалтгаан, зүй тогтлыг танихаас гадна, хийсвэр сэтгэхүй хөгжинө.	Энгийн юмсыг 1-2 гадаад шинж, төрх байдлаар нь харьцуулж, ангилж, нэгтгэн дүгнэдэг байна. Энгийн математик тооцоолол хийх чадвартай.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 2. Хэл яриа (6-10 нас)

Бол- түвшин/нас	Ухагдахуун төлөвшил		Ярих чадвар	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Бага боловсрол (6-10 нас)	Өдөр тутамдаа хэрэглэдэг үгийн утгыг илүү ойлгоно.	Бодит утгатай үг нь өдөр тутмын хэрэглээний мэддэг үгс байна. Бодит үгийн утга ялгах чадвар төлөвшсөн байхын зэрэгцээ аажмаар сайжирна.	Санаагаа бүтэн өгүүлбэрээр илэрхийлнэ.	Санаагаа илэрхийлэхдээ яриа нь ихэвчлэн энгийн өгүүлбэр ¹ -ээс бүтсэн байна. Юмс үзэгдэл, үйл явдлыг гадаад харагдаж байгаа байдлаар нь тоочин ярих хандлагатай. 1-2 өгүүлбэрээр санаагаа дүгнэсэн байна. 8-10 насанд энгийн өгүүлбэрийн хэрэглээ аажмаар багасаж, нийлмэл өгүүлбэрийн ² хэрэглээ бий болно.

¹ Энгийн өгүүлбэр нь зөвхөн өгүүлэгдэхүүн ба өгүүлэхүүний бүлгээс бүтэх бөгөөд өгүүлэхүүний нэг төвтэй байна.

² Хоёр буюу хэд хэдэн энгийн өгүүлбэрийг ямар нэгэн хэлзүйн холбоогоор холбосон өгүүлэх нэгжийг нийлмэл өгүүлбэр гэнэ.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 1. Мэдээллийг хүртэж, хүлээж авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (11-14 нас)

Бол- түвшин/нас	1. Хүртэхүй		2. Анхаарал	
Суурь боловсрол (11-4нас)	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
	Юмсын хэмжээ, хэлбэр, тоо, байрлалыг хүртэхээс гадна алслагдсан орон зайд байгаа юмсыг хүртэх чадвартай.	Юмсын хэмжээ, хэлбэр, тоо, байрлал, алслагдсан орон зайд байгаа юмсаас 7-10 хүртэлхийг зориудаар хүртэх чадвартай байх.	Зориудын анхаарал эрчимтэй хөгжинө.	Үсэг, тоо, тусгай тэмдэгтээр илэрхийлэгдсэн мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах чадвартай байх.
	3. Ой тогтоолт		4. Сэтгэхүй	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Ой тогтоолт нь хийсвэр сэтгэхүйтэй холбоотойгоор эрчимтэй хөгжинө.	Тоо, дүрс-тэмдэгт, бодит ба хийсвэр утгатай үгсийг тогтоож сэргээн санах чадвартай байх. Байнга хэрэглэгддэггүй мөн гадаад үг хэллэгтэй нарийн үйл явдлыг агуулсан өгүүлэг зэргийг тогтоон сэргээн санах чадвартай байх.	Үг хэллэгийн утгыг ойлгох чадвар нэмэгдэн тэдгээрийг хооронд нь харьцуулах, учир шалтгаанд нь сэтгэх чадвар хөгжинө.	Тэмдэгтийн системд тулгуурлан учир шалтгаан, эсрэг тэсрэг болон адил төстэй шинж, хүнд хөнгөн, хэрэглээний онцлог зэргийг харьцуулан сэтгэх чадвартай байх.	

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 2. Хэл ярианы хөгжил (11-14 нас)

Бол- түвшин/нас	Ухагдахуун төлөвшил		Ярих чадвар	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Суурь боловсрол (11-4нас)	Үгийн утгын ойлголт сайжирна.	Бодит утгатай үг нь өдөр тутмын хэрэглээний мэддэг үгс байна. Бодит үгийн утга ялгах чадвар төлөвшсөн байхын зэрэгцээ аажмаар сайжирна. Хийсвэр болон тэмдэг нэрийн утгыг ойлгох, нийтлэг шинжээр нь бүлэгт нэгтгэж ойлгох, үгсийн ерөнхий холбоо хамаарлыг нь таних чадвар дээшилнэ.	Бүтэн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх чадвар сайжирна.	Зорилго чиглэлтэй, урьдчилан төлөвлөхгүйгээр санаагаа илэрхийлэхдээ яриа нь ихэвчлэн энгийн өгүүлбэр ³ -ээс бүтсэн байна. Юмс үзэгдэл, үйл явдлыг гадаад харагдаж байгаа байдлаар нь тоочин ярих хандлагатай. Санаагаа нийлмэл өгүүлбэрээр илэрхийлэх чадвар харьцангуй сайжирна. Үйл явдал, юмсыг хараад, мөн бодол санаа, сэтгэгдлээ илэрхийлэхдээ тоочиж ярих нь эрс багасаж гол утга санаанд нь дүгнэж илэрхийлэх чадвар өмнөх настай харьцуулахад харьцангуй нэмэгдэнэ.

³ Энгийн өгүүлбэр нь зөвхөн өгүүлэгдэхүүн ба өгүүлэхүүний бүлгээс бүтэх бөгөөд өгүүлэхүүний нэг төвтэй байна.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 1. Мэдээллийг хүртэж, хүлээж авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (15-17 нас)

Бол- түвшин/нас	1. Хүртэхүй		2. Анхаарал	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Бүрэн дунд боловсрол (15-17нас)	Юмсыг бүхэлд нь, бүтцэд нь хүртэх чадвар сайжирна.	Юмсын хэмжээ, хэлбэр, тоо, байрлал, орон зай болон тогтолцоот онцлогийг таних чадвартай байх.	Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй холбоотойгоор анхаарлаа төвлөрүүлэн бүтээлчээр ажиллах чадвар нэмэгдэнэ.	Нэмэх, хасах, хуваах гэх мэт үйлдэл, үгэн хэлбэрийн мэдээлэлд анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэх чадвартай байх.
	3. Ой тогтоолт		4. Сэтгэхүй	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт

	<p>Хийсвэр сэтгэхүйн хөгжилтэй уялдан хийсвэр мэдээллийг тогтоох, утгачлан тогтоох чадвар нэмэгдэнэ.</p>	<p>Тоо, дүрс-тэмдэгт, бодит ба хийсвэр утгатай үгсийг тогтоож сэргээн санах чадвартай байх. Байнга хэрэглэгддэггүй үг хэллэгтэй нарийн үйл явдлыг агуулсан өгүүллэг, нийтлэл зэргийг тогтоон сэргээн санах чадвартай байх.</p>	<p>Учир шалтгаан, холбоо хамааралд нь сэтгэх хийсвэр сэтгэхүйн чадвар сайжирна.</p>	<p>Тэмдэгтийн системд тулгуурлан учир шалтгаан, эсрэг тэсрэг болон адил төстэй шинж, хүнд хөнгөн, хэрэглээний онцлог зэргийг харьцуулан сэтгэх чадвартай байх.</p>
--	--	--	---	--

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил
Цогц чадамж 2. Хэл ярианы хөгжил (15-17 нас)

Бол- түвшин/нас	Ухагдахуун төлөвшил		Ярих чадвар	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Бүрэн дунд боловсрол (15-17нас)	Хийсвэр үгийн утгын эзэмшилт сайжирна.	Үгийн утгыг гол шинжээр нь баримжаалан тайлбарлах чадвартай болно. Ялангуяа бодит утгатай үгийг тухайн эхэд орсон утгаар нь тайлбарлах, үгсийг утгара нь ангилах чадвар нэмэгдэнэ. Үгийн салаа утга, ижил нэрийг сайн мэддэг болсон байна. Нэрлэсэн утгатай үг хэллэг, юмсын шинж чанар заасан үгс, хийсвэр ухагдахуунаас гадна шинжлэх ухааны нэр томьёо, мэргэжлийн үг хэллэг зэргээс мэддэг болсон байна.	Санааг бүтэн өгүүлбэр, нийлмэл өгүүлэрээр илэрхийлэх, ойлгох чадвартай болно.	Зорилго чиглэлтэй, урьдчилан төлөвлөхгүйгээр ярихдаа санаагаа нэгтгэн дүгнэж илэрхийлэх хандлагатай. Нийлмэл өгүүлбэрийг хэрэглэх нь түгээмэл.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 1. Мэдээллийг хүртэж, хүлээж авах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх. (18-21 нас)

Бол/ түвшин (нас)	1. Хүртэхүй		2. Анхаарал	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Мэргэжлийн болон дээд боловсрол (18-21 нас)	Юмсын хэмжээ, хэлбэр, тоо, байрлал, орон зай болон тогтолцоот онцлогийг таних чадвартай байх.	Юмсын хэмжээ, хэлбэр, тоо, байрлал, орон зай болон тогтолцоот онцлогоос 10-12 хүртэлхийг танина.	Нэмэх, хасах, хуваах гэх мэт үйлдэл, үгэн хэлбэрийн дэс дараалалтай даалгаврыг зориудаар анхаарлаа төвлөрүүлэн гүйцэтгэх чадвартай байх.	Анхаарал шаардсан 2-3 хүртэлх цогц үйлдлийг гүйцэтгэнэ. Жишээлбэл, минутад нэмэх, хасах, хуваах болон юмсын төрөл зүйлийг ангилах үйлдлүүдээс 2-3-ыг гүйцэтгэх.
	3. Ой тогтоолт		4. Сэтгэхүй	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
	Тоо, дүрс-тэмдэгт, бодит ба хийсвэр утгатай үгсийг тогтоож сэргээн санах чадвартай байх. Байнга хэрэглэгддэггүй үг, хэллэгтэй нарийн үйл явдлыг агуулсан өгүүлэг, нийтлэл зэргийг тогтоон сэргээн санах чадвартай байх.	Мэдээллийг зориудаар хараад, сонсоод 7-8 хүртэлхийг тогтоон, сэргээн санана. Ойролцоогоор 16 хүртэлх утгын нэгж бүхий богино хэмжээний өгүүлэг, нийтлэлээс 8-13 хүртэлх утгын нэгжийг тогтоодог байна.	Тэмдэгтийн системд тулгуурлан учир шалтгаан, эсрэг тэсрэг болон адил төстэй шинж, хүнд хөнгөн, хэрэглээний онцлог зэргийг харьцуулан сэтгэх чадвартай байх.	Учир шалтгаан, зүй тогтлыг олох хийсвэр үйлдлийг минутад ойролцоогоор 1-2 хүртэлхийг гүйцэтгэнэ. 6-12 хүртэлх тэмдэгтийн систем бүхий мэдээллийг утга агуулга зэрэгт тулгуурлан харьцуулан адил төстэй ба ялгаатай шинжийг нь тодорхойлно.

Хөгжлийн бүрдэл 2. Танин мэдэхүйн хөгжил

Цогц чадамж 2. Хэл ярианы хөгжил (18-21 нас)

Бол- түвшин/ нас	Ухагдахуун төлөвшил		Ярих чадвар	
	Шалгуур	Үзүүлэлт	Шалгуур	Үзүүлэлт
Мэргэжлийн болон дээд боловсрол (18-21 нас)	<p>Үгийн утгыг гол шинжээр нь баримжаалан тайлбарлах чадвартай болно. Ялангуяа бодит утгатай үгийг тухайн эхэд орсон утгаар нь тайлбарлах чадвартай байна. Үгийн салаа утга, ижил нэрийг сайн мэддэг болсон байна. Үгийг утгаар нь бүлэглэнэ.</p> <p>Нэрлэсэн утгатай үг хэллэг, юмсын шинж чанар заасан үгс, хийсвэр ухагдахуунаас гадна шинжлэх ухааны нэр томьёо, мэргэжлийн үг хэллэг зэргээс мэддэг болсон байна.</p>	<p>Үгийг үндсэн утгаар нь товч тайлбарлах; Тэмдэг нэр, хийсвэр утгаар нь бүлэглэх чадвартай байна.</p>	<p>Зорилго чиглэлтэй, урьдчилан төлөвлөхгүйгээр ярихдаа санаагаа нэгтгэн дүгнэж илэрхийлэх хандлагатай. Нийлмэл өгүүлбэрийг хэрэглэх нь түгээмэл.</p>	<p>2-3 энгийн болон нийлмэл өгүүлбэрийн аль алийг хэрэглэхийн сацуу санаагаа дүгнэсэн байна.</p>

ГУРАВ. 6-21 настай хүүхэд, залуучуудын нийгэмшлийн шалгуур үзүүлэлт

Нийгэмшил нь хүн өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах, өөрийн зан төлөвийг хянан зохицуулах, бусадтай үр дүнтэй харилцах мэдлэг, чадвар, эзэмших, түүнийг үр дүнтэй амьдралдаа хэвшүүлэх үйл явцын нэгдэл юм.

Хүүхэд, залуучуудын нийгэмшилд гэр бүл, сургууль нийгмийн орчин, хүний туулж өнгөрүүлсэн амьдралын туршлага, байгаль, түүхийн үзэгдэл нөлөөлөх боломжтой. Үүн дотроо гэр бүлийн уур амьсгал, эцэг эхчүүдийн хүүхдэдээ хандах хандлага, сургууль, олон нийтийн үйл ажиллагааны оролцоо чухал ач холбогдолтой байна.

Нийгэмшлийг сэтгэлийн хөдөлгөөн, өөртөө хандах хандлага, харилцаа, үнэт зүйл, хэм хэмжээ, зан төлөв, дасан зохицох, ээнэгшилт гэсэн чадамжуудын цогц хэмээн үзэж, шалгуур, үзүүлэлтийг боловсруулсан.

Нийгэмшлийн шалгуур, үзүүлэлт нь 6-21 настай хүүхэд, залуучуудын нийгэмшлийн онцлог (хүрэх түвшин), хэмжих үзүүлэлт буюу илрэлийг бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшингээр тусгав.

Хүрэх түвшин нь тухайн насны хүүхэд залуучуудын нийгэмшлийн ерөнхий онцлогийг илэрхийлэх ба энэ нь шалгуур гэсэн баганад бичигдсэн. Харин үзүүлэлт гэсэн баганад тэдгээр онцлогийн хэмжигдэх боломж бүхий илрэлийг тусгалаа. Иймд энэхүү нийгэмшлийн онцлог, түүний илрэлийг эерэг ба сөрөг гэж хандахаас зайлсхийх нь зүйтэй юм.

Шалгуур, үзүүлэлт нь боловсролын бодлогын үндэслэл болох, багш, ажилтан, эцэг эхчүүд хүүхэд, залуучуудын нийгэмшлийг дэмжихийн үүднээс тэдний онцлогийг харгалзан үзэх, хүүхэд, залуучууд өөрийн нийгэмшлийг удирдан чиглүүлэхэд баримжаалал болно.

6-21 настай хүүхэд, залуучуудын нийгэмшлийн шалгуур нь сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөв, харилцаа, өөртөө хандах хандлага, дасан зохицолт, ээнэгшилт буюу эцэг эхдээ ойр дотно хандах, үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээг сахих чадамж бүхий дэд бүрдэлтэй.

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (6-10 нас)

Цогц чадамж 1,2,3. Өөртөө хандах хандлага; Зан төлөв; Сэтгэлийн хөдөлгөөн

Бол- түвшин/нас	Өөртөө хандах хандлага	
Бага боловсрол (6-10нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Өөртөө итгэлтэй байх. - Өөрийгөө хүлээн зөвшөөрдөг байх - Өөрийн үнэлэмж эерэг байх 	<ul style="list-style-type: none"> - Баяр баясгалантай. Найз нөхөд, багштайгаа харилцахдаа бэрхшээдэггүй, нийтэч. Өөрийн санаа бодлоо илэрхийлнэ. - Өөрийгөө буруутгадаггүй. Өөрийн гадаад байдал, зан чанарыг шүүмжилдэггүй. - Өөрийгөө бусадтай харьцуулдаггүй.
	Зан төлөв	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Сурах, тоглох үйл ажиллагаанд идэвхтэй - Орчны нөхцөл байдалд нийцүүлэн зан төлөвөө хянан удирдах чадвартай - Сэтгэл санааны хувьд тогтвортой - Сэтгэл гутрал, айдас бага 	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн үеэр идэвх, оролдлоготой байна. Сурах урам зоригтой. - Багшийн зааврыг дагаж биелүүлнэ. Гэрийн даалгавраа санаачилгаараа хийнэ. - Уурлаж бухимдах нь бага байна. - Уйтгартай байдлаас баяр баясгалантай байдалд амархан шилжинэ.
Сэтгэлийн хөдөлгөөн		
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг мэддэг байх - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулдаг байх 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон эцэг эх, найз нөхдийнхөө баяр хөөр, уйтгар гуниг, уур бухимдал түүний учир шалтгааныг мэддэг байна. - Өөрийг нь баярлуулж, гомдоох зүйлсийн талаарх ойлголттой байна. - Сэтгэл хөдлөлөө үгэн болон үгэн бус хэлбэрээр илэрхийлнэ. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (6-10 нас)

Цогц чадамж 4,5,6. Харилцаа; Ээнэгшилт; Дасан зохицолт

Бол- түвшин /нас	Харилцаа	
Бага боловсрол (6-10нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Идэвхтэй харилцдаг байх - Бусадтай хамтардаг байх - Гэр бүл, найз нөхөд болон үе тэнгийнхнийхээ үзэл бодлыг хүндэтгэдэг байх. 	<ul style="list-style-type: none"> - Эцэг, эх багшийн зааврыг дагаж, бусадтай мэдлэг туршлага солилцож, дэмжлэг авдаг байна. - Найз нөхөд үе тэнгийхэндээ хандах эерэг хандлагатай, хамтран ажиллах чадвартай байж, сургууль дээр зохиогдсон ажилд идэвхтэй оролцоно. - Бусдын ялгаатай байдлыг ойлгон хүндэтгэнэ.
	Ээнэгшилт	
	Шалгуур	Үзүүлэлт
	<p>Эцэг эх, асран хамгаалагчдадаа итгэдэг, тэдэнтэй ойр дотно харилцаатай байх.</p> <p>Эцэг эхтэйгээ (ойр дотны хүмүүстэйгээ) хамт байхдаа сэтгэл таатай, түшигтэй байдлыг хүүхэд мэдэрсэн байх</p>	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, асран хамгаалагч, ойр дотны хүмүүсийнхээ дэмжлэг, хайр халамжид байна. - Эцэг эх, ойр дотны хүмүүстэйгээ дотно, эерэг, нээлттэй харилцаатай байна. - Ээж аав эсвэл ойр дотны асран хамгаалагчтайгаа байх нь таатай, зарим тохиолдолд эцэг, эхийнхээ дэмжлэг тусалцаагүйгээр бие дааж асуудал шийдвэрлэж чадахгүй байх нь бий. Тэднээс тусдаа байх нь түгшүүр үүсгэх нь элбэг байна.
	Дасан зохицолт	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Бусдыг хүндэтгэж, хүлээцтэй харилцана - Өөрийн зан төлөвийг ухамсартайгаар зохицуулах чадвартай байх. 	<ul style="list-style-type: none"> - Багш болон ангийхантайгаа зөрчилдөхгүй, нөхөрсөг зан төлөвтэй байна. - Хичээл, даалгавар хийхээ ухамсарласан, хичээл зүтгэлтэй байна. - Багш, эцэг эх нь шаардлага тавих, магтан урамшуулсан тохиолдолд бие дааж ажил үүрэг гүйцэтгэнэ. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (6-10 нас)

Цогц чадамж 7,8. Үнэт зүйл; Хэм хэмжээг дагах

Бол- түвшин/ нас	Үнэт зүйл	
Бага боловсрол (6-10 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Амжилт - Аюулгүй тайван байх - Бусдад хүндэтгэлтэй хандах - Харилцаанд ялгаварлан бусдыг гадуурхахгүй байх зэрэг нь тэдний гол үнэт зүйл 	<ul style="list-style-type: none"> - Амжилтад тэмүүлэн хүчин чармайлт тавина. - Аюулгүй тайван орчин хүний амьдралд чухал гэж үзнэ. Орчны зүгээс үзүүлэх янз бүрийн хор хөнөөлтэй нөлөөллийн талаар ойлгон түүнээс өөрийгөө хамгаалах анхны дадал чадвартай байна. - Хүнийг ялангуяа ахмад хүн таньдаггүй хүнтэй хүндэлж мэндлэх, олон нийтийн газар суудал тавьж өгөх гэсэн ойлголттой, үүнийгээ зан үйлээрээ харуулдаг, хүнд туслах, аав ээжийгээ хүндлэх нь зөв гэсэн бат итгэл үнэмшилтэй. - Багш аав, ээж, ах, эгч нар нь хүнийг ялгаж дорд үзсэн хандлагыг мэдэрч заримдаа өөрийн байр сууриа илэрхийлнэ.
	Хэм хэмжээг дагах	
	Шалгуур	Үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> - Сургуулийн орчин, олон нийтийн газар албан ёсны дүрэм журмыг дагах чадвартай байх - Харилцаанд ёс зүйг баримтлах 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн орчинд дотоод дүрэм журмыг ойлгож даган биелүүлэх нь зөв гэсэн итгэл үнэмшилтэй, багшийн заавар, анги, сургууль доторх дүрэм журамд захирагдана. - Олон нийтийн газар биеэ хэрхэн зөв авч явах талаар ойлголттой, шүлсээ хаях, хог хаях, улаан гэрлээр гарах, бусдад хүндэтгэлгүй хандах, хүнийг шоолох нь буруу гэх итгэл үнэмшилтэй, үүнийг дагахыг эрмэлзэнэ. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (11-14 нас)

Цогц чадамж 1,2,3. Өөртөө хандах хандлага; Зан төлөв; Сэтгэлийн хөдөлгөөн

Бол- түвшин	Өөртөө хандах хандлага	
Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Өөртөө итгэлтэй байх. - Өөрийгөө хүлээн зөвшөөрдөг байх. - Өөрийн үнэлэмж эерэг байх. 	<ul style="list-style-type: none"> - Ердийн үед өөртөө итгэх итгэлтэй байдаг ч гэнэтийн нөхцөл байдалд өөртөө итгэх итгэлээ алдаж, амархан түгшиж болно. - Өөрийгөө бусадтай харьцуулна. Өөрийн бусдаас ялгаатай гэдгээ хүлээн зөвшөөрнө. - Өөртэй нь насанд хүрсэн хүн мэт харилцахыг хүснэ.
	Зан төлөв	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Ердийн үед өөртөө итгэх итгэлтэй байдаг ч гэнэтийн нөхцөл байдалд өөртөө итгэх итгэлээ алдаж, амархан түгшиж болно. - Өөрийгөө бусадтай харьцуулна. Өөрийн бусдаас ялгаатай гэдгээ хүлээн зөвшөөрнө. - Өөртэй нь насанд хүрсэн хүн мэт харилцахыг хүснэ. 	<ul style="list-style-type: none"> - Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд санаачилгаараа. Бусдын зүгээс өөрт нь хандах харилцаанд эмзэг ханидэвхтэй оролцоно - Найз нөхөд, үе тэнгийнхэнтэйгээ нийцтэй, тэдэнтэй цагийг хамт өнгөрүүлэх дуртай. - Амжилтгүй байдал тохиолдохвий хэмээн эмээх хандлагатайдаж болно.
	Сэтгэлийн хөдөлгөөн	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг танин мэддэг байх - Нөхцөл байдалд тохируулан өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулах, бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвартай байх. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн зэрэг сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг мэднэ. Сэтгэлийн хөдөлгөөнөө үргэлж тайван байлгаж нөхцөл байдлаас шалтгаалан зохицуулдаг ч, заримдаа зөрчилтэй нөхцөлд өөрийн үйлдэл, үгээ хянахгүй буюу сэтгэл санааных нь тэнцвэр алдагдаж болно 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (11-14 нас)

Цогц чадамж 4,5,6. Харилцаа; Ээнэгшилт; Дасан зохицолт

Бол- түвшин (нас)	Харилцаа	
Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Нээлттэй идэвхтэй харилцдаг байх - Баг, бүлгээр ажиллах чадвартай байх - Хүмүүстэй ойр дотно харилцах чадвартай байх. 	<ul style="list-style-type: none"> - Бусадтай амархан нөхөрлөж, баг бүлгээр ажиллах, секц, дугуйланд явж өөрийгөө хөгжүүлэхэд цаг гаргана - Бусдад тулгарсан асуудлыг ойлгож, багш ахмад хүмүүсийн зөвлөгөөг дагадаг ч сайн мэдэхгүй, ойр дотно бус хүмүүстэй хөндий харилцах нь ажиглагдана.
	Ээнэгшилт	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Эцэг, эхийн заавар зөвлөгөөнд хүндэтгэлтэй хандахын зэрэгцээ өөрийн санал, хүсэлтийг чөлөөтэй илэрхийлэх чадвартай. - Өөрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эцэг эх, асран хамгаалагчдаасаа туслалцаа зөвлөгөө авах 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, ойр дотны хүмүүсийнх нь хайр халамжийг чухалд үзнэ. - Эцэг эх, ойр дотны хүмүүстэйгээ хэвийн харилцаатай байна. Заримдаа тэдэнтэй нээлттэй дотно бус харилцаа ажиглагдана. Энэ нь заримдаа бусадтай амжилттай харилцаа тогтооход саад болж болно.
	Дасан зохицолт	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Бусадтай нээлттэй, нөхөрсөг харилцаатай. - Багш, эцэг эхийн заавар зөвлөмжийг дагана 	<ul style="list-style-type: none"> - Багш, эцэг эх, үе тэнгийхнийхээ үзэл бодолд эерэг ханддаг ч, зарим нөхцөлд шүүмжлэлтэй хандах талтай. - Юу хийхээ сайн ухамсарласан. Сургуулийн дотоод дүрэм, багшийн шаардлагыг баримтална. Хичээл зүтгэлтэй, итгэл найдвартай. Сурлагын амжилт зөвхөн өөрөөс нь шалтгаална гэж үздэг. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (11-14 нас)

Цогц чадамж 7,8. Үнэт зүйл; Хэм хэмжээг дагах

Боловсролын түвшин (нас)	Үнэт зүйл	
Суурь боловсрол (11-14 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Бусдад хүндэтгэлтэй хандах - Шударга харилцааг эрхэмлэнэ. 	<ul style="list-style-type: none"> - Бусад насны бүлгийг бодвол өөртөө төвлөрч бусдад хүндэтгэлтэй хандах байдал өмнөх наснаас бага зэрэг буурах нь бий. - Харилцаанд эн тэнцүү байх, найз нөхөдтэйгээ санал солилцож тэдний байр суурин дээр өөрийгөө тавих, шударга бус харилцааг мэдэрч, санаа бодлоо илэрхийлнэ.
	Хэм хэмжээг дагах	
	Шалгуур	Үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> - Сургуулийн орчин, олон нийтийн газар албан ёсны дүрэм журмыг баримталдаг байх - Харилцаанд ёс зүйг баримтлах 	<p>Анги, сургууль доторх дүрэм журам, багш, ахмад хүмүүсийн заавар зөвлөмжийг хүлээж авах нь тэдний сэтгэл санаа, нөхцөл байдлаас шалтгаална.</p> <ul style="list-style-type: none"> - Олон нийтийн газар биеэ авч явах дадал зуршилтай ч, заримдаа шүлсээ хаях, хог хаях, улаан гэрлээр гарах, бусдад хүндэтгэлгүй хандах байдал ажиглагдах талтай. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (15-17 нас)

Цогц чадамж 1,2,3. Өөртөө хандах хандлага; Зан төлөв; Сэтгэлийн хөдөлгөөн

Бол- түвшин (нас)	Өөртөө хандах хандлага	
Бүрэн дунд боловсрол (15-17 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмж, өөрийгөө хүлээн зөвшөөрөх нь нэмэгдсэн байх 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн амжилт, гадаад байдалд сэтгэл хангалуун. Ажиллах эрч хүч урам зоригтой байна. Бусадтай харилцахдаа санаа бодлоо гадаад үйлдэл, хөдөлгөөнөөрөө чөлөөтэй, идэвхтэй илэрхийлнэ. - Амжилтаараа бахархана. Өөрийн амжилтгүй байдлыг хүлээн зөвшөөрч чадахгүйгээс уурлан бухимдах, сэтгэлээр унах хандлага ажиглагдаж болно.
	Зан төлөв	
	Шалгуур	Үзүүлэлт
	<p>Үйл ажиллагаанд идэвхтэй оролцох чадвартай</p> <p>Үе тэнгийнхэн болон өөрөөсөө ахмад хүмүүстэй нийцтэй зан харилцаатай</p> <p>Сэтгэлийн түгшүүр ажиглагдана</p>	<ul style="list-style-type: none"> - Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанаас гадна нийгмийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцоно. - Үе тэнгийнхэн, гэр бүл, бусадтай нийцтэй зан харилцаатай, хэм хэмжээ ёс суртахууныг даган баримтлах нь илэрхий ажиглагдана. - Ирээдүйн амьдралдаа санаа тавих, ямар хүн болох вэ гэдэгт анхаарал хандуулна.
	Сэтгэлийн хөдөлгөөн	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвартай байх. - Нөхцөл байдалд тохируулан тохируулан өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулах чадвартай байх 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын эерэг, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгодог ч зөрчилдөөнт нөхцөлд сэтгэлийн хөдөлгөөндөө автагдаж болох буюу уурлаж бухимдсан үедээ өөрийгөө тайвшруулах, сэтгэл хөдлөлөө үгэн болон үгэн бус аргаар илэрхийлэх нь дутагдалтай байж болно. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (15-17 нас)

Цогц чадамж 4,5,6. Харилцаа; Ээнэгшилт; Дасан зохицолт

Бол- түвшин	Харилцаа	
Бүрэн дунд боловсрол (15-17 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Нийтэч, идэвхтэй байх. - Баг, бүлгээр ажиллах, олон нийттэй харилцах чадвартай байх. - Бусдын сэтгэл санааг ойлгох харилцдаг байх. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн байр сууриа илэрхийлдэг, таагүй нөхцөл байдалд тохиромжтой хариу үйдлийг үзүүлнэ. - Дугуйлан, олон нийтийн үйл ажиллагаа, өөрийгөө хөгжүүлэхэд цаг гаргана
	Ээнэгшилт	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхийн анхаарал халамжийг мэдэрч, ойлгосон байх 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, ойр дотны хүмүүсийнхээ дэмжлэг, хайр халамжид бүрэн итгэнэ, хоорондын харилцан ойлголцол хэвийн. Эцэг эхтэйгээ цуг байх нь ихэнхдээ таатай. Эцэг эхээсээ тусдаа байх чадвартай, бие даан эцэг эх, асран хамгаалагчаасаа хол байх чадвартай. - Эцэг, эх ойр дотны хүмүүстэйгээ эерэг харилцаатай. Сэтгэлийн хөдөлгөөний нээлттэй харилцаа давамгайлдаг.
	Дасан зохицолт	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Бусдын үзэл бодол, үйлдэлд өөрийн байр сууринаас хандана. <p>Өөрийн зан төлөвийг ухамсартайгаар зохицуулах чадвартай байх</p>	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл, найз нөхдийнхөө бодол санаа, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандана. - Дүрэм журмыг бараг зөрчихгүй, ихэнх тохиолдолд буруугаа хүлээн зөвшөөрнө. - Эцэг эх багш бусад насанд хүрэгчдийн хяналт шаардлага шаардлагатай байх нь бий. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (15-17 нас)

Цогц чадамж 7,8. Үнэт зүйл; Хэм хэмжээг дагах

Бол- түвшин (нас)	Үнэт зүйл	
Бүрэн дунд боловсрол (15-17 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Шударга харилцааг эрхэмлэх - Аюулгүй хамгаалттай байдлыг чухалчилах 	<ul style="list-style-type: none"> - Харилцаанд эн тэнцүү байх, найз нөхөдтэйгээ санал солилцож тэдний байр суурин дээр өөрийгөө тавих, бусад хүмүүс болон өөрт нь шударга бус хандаж буйг мэдэрч байр сууриа илэрхийлнэ. - Өөрийн байгаа орчиндоо аюулгүй тайван байх хүсэлтэй, тийм орчин бүрдүүлэхийг хичээдэг.
	Хэм хэмжээг дагах	
	Шалгуур	Үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> - Сургууль, олон нийтийн газар албан ёсны дүрэм журмыг дагах - Нийгмийн харилцаанд ёс зүйг баримтлах чадвартай байх 	<ul style="list-style-type: none"> - Сургууль, олон нийтийн орчинд хэв журмыг баримталж, багш ахмад хүмүүсийн заавар дүрмийг биелүүлнэ. - Олон нийтийн газар биеэ зөв авч явах, бусдыг хүндэтгэх, нийцтэй харилцана. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (18-21 нас)

Цогц чадамж 1,2,3. Өөртөө хандах хандлага; Зан төлөв; Сэтгэлийн хөдөлгөөн

Бол- түвшин (нас)	Өөртөө хандах хандлага	
Мэргэжлийн болон дээд боловсрол (18-21 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмж, өөрийгөө хүлээн зөвшөөрөх нь нэмэгдсэн байх 	Өөртөө хандах зэрэг хандлага хадгалагдана.
	Зан төлөв	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Сурах үйл ажиллагаа болон амьдралын бүхийл хүрээнд идэвхтэй хандах чадвартай байх. - Хүмүүс хоорондын харилцааны зөрчил бага, нийгмийн тогтсон хэм хэмжээг баримтлах чадвартай байх. 	<ul style="list-style-type: none"> - Зорилго тавьж түүндээ хүрэхийн төлөө өөрийгөө дайчилна. Идэвх урам зоригтой. - Хэм хэмжээг зөрчдөггүй. Өөрөө баримлахаас гадна бусдыг мөн баримтлахыг хүснэ. - Бусадтай харилцаа холбоо тогтоохдоо санаачилгатай биш ч бэрхшээдэггүй. Ирээдүйн амьдралын төлөвлөгөөтэй холбоотой түгшүүр үүсч болно.
	Сэтгэлийн хөдөлгөөн	
	Шалгуур	Үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгон, мэддэг байх - Зэрэг сэтгэлийн хөдөлгөөнөө хадгалж, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө хянан зохицуулдаг чадвартай байх 	<ul style="list-style-type: none"> - Бусдын болон өөрийн бие хүний онцлогтой холбоотой сэтгэлийн хөдөлгөөн, түүний шалтгааныг мэддэг байна. - Амьдралын баяр баясгалантай, уурлаж бухимдсан үедээ өөрийгөө тайвшруулах аргатай буюу тэвчээртэй зантай. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (18-21 нас)

Цогц чадамж 4,5,6. Харилцаа; Ээнэгшилт; Дасан зохицолт

Бол- түвшин (нас)	Харилцаа	
Мэргэжлийн болон дээд боловсрол (18-21 нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Хариуцлагатай , эерэг харилцах - Нийгмийн харилцаанд идэвхтэй - Бусдын үзэл бодол, сэтгэл санааны байдлыг ойлгон хүлээн зөвшөөрдөг. 	<ul style="list-style-type: none"> - Өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ харилцааны дүрмийг баримталж, бусадтай зөрчилд орохгүй харилцана - Бүхий л талын үйл ажиллагаанд оролцоно - Бусдын сэтгэл санааг ойлгож харилцах дотно хандлага гаднаа тодорхой ажиглагдана.
	Ээнэгшилт	
	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхийн анхаарал халамжийг ойлгосон, гаднаа тодорхой илэрнэ. 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, ойр дотны хүмүүстэй бүрэн харилцан ойлголцоно, дотно харьцаа хандлагатай ба эцэг эхдээ анхаарал халамж тавьж байгаа нь илэрхий ажиглагдана.
	Дасан зохицолт	
Шалгуур	Үзүүлэлт	
<ul style="list-style-type: none"> - Өөрийн хүрээлэл, бусдыг хүлээн зөвшөөрнө - Өөрийн зан төлөвийг ухамсартайгаар зохицуулах чадвартай байх 	<ul style="list-style-type: none"> - Бусдын бодол санаа, үйл хөдлөлд эерэгээр хандах чадвартай байна. Бараг зөрчилдөхгүй. - Хариуцлагаа ухамсарлан, бие даан асуудалд хандах, итгэл хүлээх чадвартай байна. 	

Хөгжлийн бүрдэл 3. Нийгэмшил (18-21 нас)

Цогц чадамж 7,8. Үнэт зүйл; Хэм хэмжээг дагах

Бол- түвшин (нас)	Үнэт зүйл	
Мэргэжлийн болон дээд боловсрол (18-21нас)	Шалгуур	Үзүүлэлт
	<ul style="list-style-type: none"> - Бусдад хүндэтгэлтэй хандах чадвартай байх. - Хүмүүстэй нийцтэй байх. - Уламжлал ёс заншилд хүндэтгэлтэй хандах 	<ul style="list-style-type: none"> - Найз нөхөд, гэр бүл, нийгмийн хүрээлэлд хүндэтгэлтэй байгаагаа үйлдлээрээ идэвхтэй харуулна. - Бусдын бодолд санаанд хүндэтгэлтэй хүлээцтэй, нийцтэй хандана. - Уламжлалт ёс заншлыг эрхэмлэх нь зөв гэсэн бодолтой. Уламжлал ёс заншлыг ойлгож дагана.
	Хэм хэмжээг дагах	
	Шалгуур	Үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> - Сургууль, олон нийтийн газар албан ёсны дүрэм журмыг баримтлах - Нийгмийн харилцааны хэм хэмжээ, ёс зүйг баримтлах 	<p>Сургууль, олон нийтийн газрын дүрэм журам, бусдын заавар зөвлөмжийг хүлээж авна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн харилцаанд бусдад хүндэтгэлтэй хандах, бусдын ялгаатай байдлыг харгалзан үзнэ. 	

Ашигласан материал

- (2012). Антропология. /М.А.Негашева и др- Учебник, - М.Научный мир, -С.250.
- (2005).Антропоэкология Центральной Азии. / Т.И. Алексеева, В.А. Бацевич, Р.М. Мунчаев и др; под ред. Т.И. Алексеевой. – М.: Научный мир, 85–201.
- (1981).Батчулуун Д. Физическое развитие детей от 1-го месяца до 17 лет и некоторые гигиенические вопросы акселерации развития школьников г. Улан-Батора: Дис... канд. мед. наук. – Улан-Батор, 22 с.
- (1992). Батчулуун д, Цолмон.Ч. Хүүхэд өсвөр үеийнхний эрүүл ахуй, -Зуун мод, X 90.
- (1941). Бунак В.В. Антропометрия, 368 с.
- (2009). Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан, - 2010а
- (1997). Ганбаатар Р. Научное обоснование нормативных требований физической подготовки призывной молодежи Монголии в возрасте 18–25 лет: Автореф. канд. мед. наук. – Улан-Батор,– 26 с.
- (2010).Година Е.З., - Впору ли юношесдоспехи рыцаря? / - Московская правда газета, № 12 (65), стр 3.
- (2007). Гундэгмаа Л. Монголын оюутан ЗАЛУУЧУУДЫН бие бялдрын есэлт хөгжилтийн онцлог // Биеийн тамир, спортын онол, арга зүй. № 02 (3) – С.10–15.
- (2000).Уранчимэг Ш. Хотжилтые орчин дахь монгол хуухдуудийн бие бялдрын усулт хугжлийн онцлог: Дэд докторын зэрэг горилсон диссертаци. – УБ. хот. – 140 с.
- (1991). Чойбалсан Л. Нормативные требования к физическому развитию и физической подготовленности допризывной молодежи (16–18 лет) МНР: Автореф. ... канд. пед. наук. – М.,– 28 с.
- (1967). Чултэмдорж Ч, Сурагчдын бие бялдрын хугжилтийн зарим асуудалд // Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх газар. – Улан-Батор,– 51 х.
- (1998). Эрдэнэ М. Монголын байгаль газар зүйн янз бүрийн бусийн хуухдуудийн бие бялдрын усулт хугжилтийн онцлог: БУ-ны дэд докторын зэрэг горилж бичсэн бүтээл, 139 х.
- (2008). Euling et al. Examination of US puberty-timing data from 1940 to 1994 for secular trends panel findings (22 pages) Bogin, Barry, Patterns of Human Growth (2nd ed.)- Cambridge, UK & New York: Cambridge University Press

Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн
шалгуур, үзүүлэлт
ЗӨВЛӨМЖ